

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-14
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	15-45
<hr/>	
1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	15-35
2. “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	35-43
3. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 19 гишүүн 2023.12.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	43-44
4. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Шүүх байгуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий/	44-45
5. Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 1 дүгээр сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	45

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 25 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Л.Мөнхбаатар, Ж.Сүхбаатар, Н.Учрал;
Тасалсан: Ш.Адьяаа, Э.Бат-Амгалан, С.Бямбацогт.

Нэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, мөн шүүхийн Иргэний хэргийн танхимын шүүгч Н.Баярмаа, Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, ахлах шинжээч Ш.Цолмон, Цагдаагийн ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албаны дэд дарга Б.Батсуурь, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын дарга Д.Энхтөр, Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн Б.Энхболд, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Л.Данзанноров, Монголын Криминологичдын холбооны удирдах зөвлөлийн дарга Б.Батзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгээс гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ц.Мөнх-Оргил танилцуулав.

Санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Д.Ганбат нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ц.Мөнх-Оргил, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Монголын Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Л.Данзанноров, Монголын Криминологичдын холбооны удирдах зөвлөлийн дарга Б.Батзориг нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ц.Мөнх-Оргил, Монголын Криминологичдын холбооны удирдах зөвлөлийн дарга Б.Батзориг, Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн Б.Энхболд, Монголын Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Л.Данзанноров, Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын шүүгч Н.Баярмаа нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 2, 4, 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Н.Алтанхуяг, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд /цаашид “ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 2.2 дугаар зүйлийн 10, 11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.Энэ хуулийн 31.4 дүгээр зүйлд заасан үндэслэлээр сэжигтнийг баривчлах тухай прокурорын саналыг уг хэрэг гарсан газрын харьяалах шүүх хянан шийдвэрлэнэ.

11.Энэ хуулийн 31.5 дугаар зүйлд заасны дагуу сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчилсан тухай мөрдөгчийн шийдвэрийг уг хэрэг гарсан газрын харьяалах шүүх, хэрэв баривчлагдсан сэжигтнийг 24 цагийн дотор уг хэрэг гарсан газрын харьяалах шүүхэд хүргэх боломжгүй бол баривчлах ажиллагаа явагдсан газрын шүүх хянан шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 3.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “Шүүх энэ хуулийн” гэсний дараа “14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3, 1.5 дахь заалт,” гэж нэмж, 3.1 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 14.10 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “5 хоногийн өмнө” гэснийг “7-оос доошгүй хоногийн өмнө” гэж, 8 дахь хэсгийн “4 хоногийн өмнө” гэснийг “4-өөс доошгүй хоногийн өмнө” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 14.10 дугаар зүйлийн Тайлбарыг доор доор дурдсанаар өөрчлөн найруулж, 11, 12 дахь хэсэг болгох:

“11.Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор, оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүгдэгчид урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, цагдан хорих хугацааг сунгахад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж дуустал цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.

12.Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад шүүгдэгчийг цагдан хорьсон хугацаа нь энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хугацаанд хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 17.2 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.Прокурор, мөрдөгч яллагдагчид энэ хуулийн 7 дугаар бүлэгт заасан эрх, үүргээс гадна дараах эрхийг тусгайлан танилцуулна:

6.1.Тухайн гэмт хэрэгт оногдуулахаар заасан эрүүгийн хариуцлагын төрөл хэмжээний талаар мэдээлэл авах

6.2.Прокурорын санал болгосон эрүүгийн хариуцлагын төрөл хэмжээг хүлээн зөвшөөрөх эсвэл татгалзах;

6.3.Эрүүгийн хариуцлагын төрөл хэмжээний талаар өөрийн саналыг илэрхийлэх;

6.4.Шүүх шийдвэр гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэхээс татгалзах.

7.Прокурор хохирогчид энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шийдвэрийг мэдэгдэж, хохирол нөхөн төлөх талаар яллагдагчийн гаргасан санал болон энэ хуулийн 8 дугаар бүлэгт заасан эрх, үүргийг тусгайлан танилцуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 17.2 дугаар зүйлийн 8, 9 дэх хэсгийн “хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй” гэснийг “ердийн журмаар хянан шийдвэрлэнэ.” гэж тус тус өөрчилж, 11 дэх хэсгийн “Эрүүгийн хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэсэн нь” гэсний дараа “мөрдөн шалгах ажиллагааны явцад” гэж нэмж, 17.2 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 1
Бүгд: 11
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 17.3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5.1 дэх заалтын “тохиролцоо хийгдсэн огноо” гэснийг “прокурорын санал танилцуулсан он, сар, өдөр” гэж өөрчилж, 17.3 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.Прокурор яллах дүгнэлтийн хувийг яллагдагчид гардуулж, хавтаст хэргийг харьяалах шүүхэд шилжүүлсэн тухай яллагдагч, хохирогч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч өмгөөлөгчид мэдэгдэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 1
Бүгд: 11
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 14.9 дүгээр зүйлийн нэг дэх хэсгийн “өөр төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авах боломжгүй гэж үзвэл” гэснийг хасаж, 1.1 дэх заалтын “оргон зайлсан” гэсний өмнө “эсхүл” гэж, 14.9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “саналыг үндэслэн” гэсний дараа “шүүх” гэж тус тус нэмж, 14.9 дүгээр зүйлийн 1.2 дахь заалтын “сүрдүүлсэн” гэснийг “эсхүл, сүрдүүлсэн, эсхүл нөлөөлсөн” гэж, 2.1 дэх заалтын “1.1, 1.3-т” гэснийг “1.1, 1.2, 1.3”-т гэж тус тус өөрчилж, 14.9 дүгээр зүйлийн 2.3, 2.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2.3, 2.4, 2.5 дахь заалт болгох:

“2.3.зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэрэг гэмт хэрэгт хамтран оролцсон;

2.4.Монгол Улсад оршин суух газрын хаяг тодорхойгүй, эрхэлсэн ажилгүйн улмаас түүнийг мэдэгдэх хуудсаар дуудах боломжгүй;

2.5.Монгол Улсад байнга оршин суудаггүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 17.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн “талууд” гэснийг “прокурор” гэж, “гохиолдолд” гэснийг “үндэслэлээр” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 31.5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“31.5 дугаар зүйл сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчлах

1.Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт холбогдуулан сэжигтнийг дараах үндэслэлээр хойшлуулшгүйгээр баривчилж болно:

1.1.гэмт хэрэг үйлдэж байх үед, эсхүл үйлдсэн дор нь, эсхүл гэмт хэрэг үйлдсэн газраас зугтах үед нь барьсан;

1.2.гэмт хэрэг үйлдсэн даруй гэрч, хохирогч шууд заасан;

1.3.хэргийн газарт болон тухайн хүний хувцас, бие, орон байр, эд зүйл, тээврийн хэрэгсэлд ул мөр илэрсэн.

2.Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэгт холбогдуулан сэжигтнийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дараах үндэслэлийн аль нэг нь тогтоогдвол хойшлуулшгүйгээр баривчилж болно:

2.1.хэн болох нь тогтоогдоогүй;

2.2.Монгол Улсад оршин суух газрын хаяг тодорхойгүй, эрхэлсэн ажилгүйн улмаас түүнийг мэдэгдэх хуудсаар дуудах боломжгүй;

2.3.Монгол Улсад байнга оршин суудаггүй.

3.Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүнд гэмт хэрэг үйлдсэн даруй энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад үндэслэл бүхий сэжиг тогтоогдвол сэжигтнийг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан аль нэг үндэслэлээр хойшлуулшгүйгээр баривчилж болно.

4.Мөрдөгч сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчилсан даруй прокурорт мэдэгдэж, прокурор баривчлах ажиллагаа хуульд нийцсэн эсэхийг хянаж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

4.1.мөрдөгчийн шийдвэрийг баталж, шүүхэд даруй хүргүүлэх;

4.2.мөрдөгчийн шийдвэрийг үндэслэлгүй, эсхүл үргэлжлүүлэн баривчлах шаардлагагүй гэж үзвэл батлахаас татгалзаж, тэмдэглэл үйлдэх.

5.Үндэслэлгүйгээр баривчлагдсан сэжигтнийг прокурор даруй суллана.

6.Мөрдөгч энэ хуулийн 30.17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлтэй бол хойшлуулшгүйгээр баривчилсан сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналаа сэжигтнийг баривчилснаас хойш прокурорт даруй хүргүүлнэ.

7.Прокурор мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл саналыг хүлээн авснаас хойш 6 цагийн дотор баривчилсан сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах эсэхийг шийдвэрлэнэ.

8.Прокурор сэжигтэн сэжигтнийг баривчилсан шийдвэрийг хүчинтэйд тооцуулах, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, хязгаарлалт тогтоох, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай саналаа баривчлах хугацаа дуусахаас 24 цагийн өмнө шүүхэд хүргүүлнэ.

9.Шүүх энэ зүйлийн 8 дахь хэсэгт заасан прокурорын саналыг хүлээн авснаас хойш даруй, эсхүл 24 цагийн дотор шүүхийн хэлэлцүүлгийг товлон явуулж, прокурорын саналыг үндэслэн баривчлах ажиллагааг хүчинтэйд тооцох, яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг хянан шийдвэрлэнэ.

10.Прокурор, эсхүл баривчлах байрны даргын шийдвэрээр суллагдсан сэжигтэн, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч уг хэрэг гарсан газрын харьяалах шүүхэд баривчлах ажиллагааны талаар сэжигтнийг суллагдсанаас хойш 10 хоногийн дотор гомдол гаргаж болно. Прокурор гомдолд холбогдох материалыг харьяалах шүүхэд даруй хүргүүлнэ.

11.Шүүх энэ зүйлийн 10 дахь хэсэгт заасан гомдлыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор энэ хуульд заасан нийтлэг журмын дагуу шүүхийн хэлэлцүүлгийг товлон явуулж, баривчлах ажиллагааг хүчинтэйд тооцох эсэхийг хянан шийдвэрлэнэ. Энэ шийдвэрт гомдол гаргахгүй.

12.Энэ зүйлийн 10 дахь хэсэгт заасны дагуу суллагдсан хүн гомдол гаргаагүй бол холбогдох шийдвэрийг 30 хоногийн дотор харьяалах шүүхэд хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулж Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 1

Бүгд: 12

91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “15.8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “тухайн шатын шүүхийн Ерөнхий шүүгч, түүний эзгүйд томилсон шүүгч” гэснийг “давж заалдах шатны шүүх” гэж” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэснийг хасаж, 31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 3 дугаар зүйлд 6 дахь заалт болгон нэмэх:

“6/31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Мөрдөгч сэжигтнийг баривчлах үед түүнийг ямар хэрэгт холбогдуулан баривчилж байгаа талаар мэдэгдэж, энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан эрхийг сануулна.”” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “31.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн” гэснийг хасаж, 31.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 3 дугаар зүйлд 7 дахь заалт болгон нэмэх:

“7/31.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Сэжигтэнд баривчлах тухай шүүхийн шийдвэрийг танилцуулсан, эсхүл хойшлуулушгүйгээр баривчилсан тохиолдолд энэ хуулийн 31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг танилцуулсан үеэс баривчилсан хугацааг тоолох бөгөөд сэжигтнийг мөрдөн шалгах байгууллагад хүргэх, зайлшгүй эмнэлгийн туслалцаа үзүүлэх, эрүүлжүүлэх, өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзахад зарцуулсан хугацааг энэ хуулийн 31.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан хугацаанд оруулан тооцохгүй. Өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах хугацаа 1 цагаас илүүгүй байна.”” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр, томъёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Хууль хэрэгжих хугацааг тодорхой болгох шаардлагатай тул “Хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл”-ийг ажлын хэсгээс боловсруулж, хэлэлцүүлье гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын шүүгч Н.Баярмаа, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Б.Ундрах, Н.Баасанжав, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тэргүүн дэд дарга Ч.Оюунцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, мөн газрын Хувийн эрх зүйн хэлтсийн шинжээч М.Оюунчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгээс гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ц.Мөнх-Оргил танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Н.Алтанхуяг, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд /цаашид “ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 1, 2 дугаар зүйл болгох:

“1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай Долдугаар¹ бүлэг нэмсүгэй:

“ДОЛДУГААР¹ БҮЛЭГ

Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа

75¹ дүгээр зүйл.Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх хэрэг

75¹.1.Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй мөнгөн хөрөнгө гаргуулах дараах нэхэмжлэлийг шүүгч дангаар тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ:

75¹.1.1.бүх төрлийн гэрээний дагуу мөнгөн хөрөнгө гаргуулах;

75¹.1.2.дундын өмчийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардал гаргуулах;

75¹.1.3.хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс гаргуулах;

75¹.1.4.бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд гэм хор учруулсны улмаас мөнгөн хөрөнгө гаргуулах.

75¹.2.Дараах нэхэмжлэлийг үнийн дүнгээс үл хамааран шүүх тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ:

75¹.2.1.шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор эд хөрөнгө, эрхийг битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдаа явуулах ажиллагаатай холбоотой гомдол;

75¹.2.2.энэ хуулийн 75¹.1.1-д заасан гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах нэхэмжлэл;

75¹.2.3.ажилд эгүүлэн тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх олговор гаргуулах нэхэмжлэл.

75¹.3.Эрх зүйн нэг маргаанаас үүдэлтэй шаардлагыг хэд хэдэн нэхэмжлэлээр хэсэгчлэн гаргахыг хориглоно.

75¹.4.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуулиар тогтоосон журмын дагуу шийдвэрлэнэ.

75¹.5.Гэр бүл, өв залгамжлалын холбогдолтой бүх төрлийн хэрэгт тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх журам үйлчлэхгүй.

75² дугаар зүйл.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх зарчим, хугацаа

75².1.Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэг шүүх хуралдаанаар, бичмэл болон цахим нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэнэ.

75².2.Зохигч шүүх хуралдаанаас өмнө, энэ бүлэгт заасан хугацааны дотор өөрийн шаардлага, татгалзлын үндэслэл болж байгаа байдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй.

75².3.Иргэний хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 45 хоног, давж заалдах шатны шүүхээс хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ.

75².4.Энэ хуулийн 75².3-т заасан хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 14 хүртэл хоногоор сунгаж болно.

75³ дугаар зүйл.Хэрэг үүсгэх, нэхэмжлэл гардуулах

75³.1.Шүүгч энэ хуулийн 75¹ дүгээр зүйлд заасан шаардлага хангагдсан бөгөөд энэ хуулийн 65.1-д заасан үндэслэл байхгүй гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 5 хоногийн дотор иргэний хэрэг үүсгэх тухай захирамж гаргана.

75³.2.Энэ хуулийн 75⁴ дүгээр зүйлд заасны дагуу хариуцагчид мэдэгдэх хуудсыг хүргүүлэхдээ нэхэмжлэлийн хувийг хэргийн оролцогчийн эрх, үүргийн тайлбарын хамт

илгээнэ. Хэрэв мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийн хувь, эрх, үүргийн тайлбарыг баталгаат шуудангаар илгээсэн, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлснийг энэ хуулийн 77 дугаар зүйлд заасны дагуу хариуцагч хүлээн авсан бол ийнхүү хүлээн авсан өдрөөр, энэ хуулийн 75⁴.4-т заасны дагуу хүргүүлсэн бол мөн зүйлд заасан мэдэгдэх хуудас хүлээн авсанд тооцох өдрийг нэхэмжлэлийн хувийг гардаж авсан өдөр гэж үзнэ.

75³.3.Нэхэмжлэл, хариу тайлбар, хэргийн оролцогчийн эрх, үүргийн тайлбарын загварыг Улсын дээд шүүх батална.

75⁴ дүгээр зүйл.Мэдэгдэх хуудсыг хүргүүлэх

75⁴.1.Шүүх энэ хуулийн 77.2-т заасны дагуу мэдэгдэх хуудсыг баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлсэн боловч хариуцагч тухайн хаягт оршин суудаггүй, үйл ажиллагаа явуулдаггүй бол хариуцагч иргэний болон хуулийн этгээдийн бүртгэлийн дугаар, эсхүл регистрийн дугаарыг мэдээлсэн нэхэмжлэлийн тухайд албан ёсны хаягийг улсын бүртгэлийн байгууллагаас тодруулах ажиллагааг шүүх санаачилгаараа хийнэ.

75⁴.2.Энэ хуулийн 75⁴.1-д заасны дагуу улсын бүртгэлийн байгууллагаас тодруулж ирүүлсэн хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн боловч хариуцагч тухайн хаягт оршин суудаггүй, үйл ажиллагаа явуулдаггүй бол иргэн, хуулийн этгээдтэй төрийн байгууллагаас харилцах төрийн мэдээллийн нэгдсэн системийн иргэний болон хуулийн этгээдийг итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээдийн бүртгэлийн дугаар бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээнэ.

75⁴.3.Энэ хуулийн 75⁴.2-т заасан цахим шуудангийн хаягаас гадна хариуцагчийн албаны болон хувийн цахим шуудангийн хаягийн мэдээллийг нэхэмжлэлд тусгасан бол эдгээр хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг давхар илгээнэ.

75⁴.4.Энэ хуулийн 75⁴.2, 75⁴.3-т заасны дагуу цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээснээс хойш 7 хоног өнгөрсөн бол мэдэгдэх хуудсыг хүлээн авсанд тооцно.

75⁵ дугаар зүйл.Хариу тайлбар, сөрөг нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлэх, гуравдагч этгээд оролцох

75⁵.1.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэгтгэх, тусгаарлах, бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд, хамтран нэхэмжлэгч, хамтран хариуцагч татан оролцуулах ажиллагаа хийгдэхгүй.

75⁵.2.Хариуцагч нэхэмжлэлийг гардаж авснаас хойш 7 хоногийн дотор сөрөг нэхэмжлэл гаргаж болно.

75⁵.3.Сөрөг нэхэмжлэл энэ хуулийн 73, 75¹ дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

75⁵.4.Зохигч үндсэн ба сөрөг нэхэмжлэлийг гардан авснаас хойш 5 хүртэл хоногийн дотор нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлэх үүрэгтэй.

75⁵.5.Нэхэмжлэгч иргэний хэрэг үүсгэснээс хойш 5 хоногийн дотор энэ хуулийн 75¹ дүгээр зүйлд заасан шаардлага, үндсэн нэхэмжлэлд заасан үндэслэлийн хүрээнд

нэхэмжлэлийн шаардлагаа нэг удаа нэмэгдүүлж болно. Нэхэмжлэлийн шаардлагыг нэмэгдүүлснийг хэргийн оролцогчид мэдэгдэнэ.

75⁵.6.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусдын эрх хөндөгдсөн тохиолдолд тэдгээр нь бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдээр оролцож болно.

75⁶ дугаар зүйл.Гэрчийн мэдүүлэг

75⁶.1.Гэрч энэ хуулийн 43.3-т заасан эрх, үүргийг ойлгосны үндсэн дээр үнэн зөв мэдүүлснээ илэрхийлэн, нотариатаар гэрчлүүлсэн мэдүүлгийг шүүхэд ирүүлсэн нь хангалттай гэж шүүх үзвэл нотлох баримтаар үнэлж болно.

75⁶.2.Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн тусламжтай гэрч, шүүгч, зохигч нэгэн зэрэг холбогдон авсан гэрчийн мэдүүлгийг хангалттай гэж шүүх үзвэл нотлох баримтаар үнэлж болно.

75⁶.3.Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжүүлсэн нь гэрчийн мэдүүлгийг энэ хуулийн 75⁶.2-т заасны дагуу үнэлэхэд саад болохгүй.

75⁷ дугаар зүйл.Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжлэх

75⁷.1.Шүүгч иргэний хэрэг үүсгэснээс хойш дараах нөхцөл байдал тогтоогдвол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулах тухай захирамж гаргаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлнэ:

75⁷.1.1.нэхэмжлэл гаргах, эсхүл иргэний хэрэг үүсгэхдээ энэ хуулийн 75¹ дүгээр зүйлд заасныг зөрчсөн;

75⁷.1.2.тухайн хэрэг нь эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой байж болзошгүй гэж үзсэн.

75⁷.2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулах тухай шүүгчийн захирамжид гомдол гаргахгүй.

75⁷.3.Хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхээс тогтоосон тов ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хүчинтэй хэвээр байна.

75⁷.4.Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхээр үргэлжлүүлсэн нь хэрэг хянан шийдвэрлэх хугацааг шинээр тоолох үндэслэл болохгүй.

75⁸ дугаар зүйл.Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх

75⁸.1.Шүүгч иргэний хэрэг үүсгэснээс хойш энэ хуулийн 74.1-д заасан үндэслэл бүрдвэл хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэнэ.

75⁹ дүгээр зүйл.Хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр

75⁹.1.Энэ хуулийн 75⁷.1-д зааснаас бусад тохиолдолд шүүх энэ хуулийн 75¹.1, 75¹.2-т заасан шүүх хуралдаанаас шийдвэр гаргана.

75⁹.2.Энэ хуулийн 75⁹.1-д заасан шийдвэр нь удиртгал, үндэслэх, тогтоох хэсэгтэй байх бөгөөд үндэслэх хэсэгт нэхэмжлэлийн шаардлага, татгалзал, шийдвэрийн үндэслэлийн товч агуулгыг дурдана.

75⁹.3.Шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор энэ хуулийн 75³.2-т заасны дагуу зохигч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид гардуулна.

75⁹.4.Энэ хуулийн 75⁹.2 дахь хэсэг давж заалдах шатны шүүхийн магадлалд нэгэн адил үйлчилнэ. Шийдвэр, магадлалын бүтэц, боловсруулах аргачлалыг Улсын дээд шүүх батална.

75¹⁰ дугаар зүйл.Шүүхийн шийдвэрээр нэмэлт хугацаа тогтоох, хуваарь гарган хэсэгчлэн төлөх

75¹⁰.1.Нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн, эсхүл хэсэгчлэн хангасан бол хариуцагчийн санхүүгийн байдал, харгалзвал зохих бусад зайлшгүй шалтгаанаар, хариуцагчийн хүсэлтэд үндэслэн шийдвэрийг биелүүлэх нэмэлт хугацаа тогтоох, эсхүл хуваарийн дагуу хэсэгчлэн төлөхөөр шүүхийн шийдвэрт зааж болно. Нэмэлт хугацаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш зургаан сараас илүүгүй байна.

75¹¹ дүгээр зүйл.Давж заалдах гомдол гаргах

75¹¹.1.Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ хуулийн 75⁹.3-т заасны дагуу гардуулснаас хойш 7 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болно.

75¹¹.2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд давж заалдах шатны шүүх хэргийг эцэслэн шийдвэрлэнэ.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 19 гишүүн 2023.12.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу хууль санаачлагч хуралдаанд оролцоогүй тул Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хойшлуулав./16:21/

Дөрөв. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Шүүх байгуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Тав. Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 1 дүгээр сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 01 дүгээр сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 02 минут үргэлжилж, 19 гишүүнээс 13 гишүүн ирж, 68.5 хувийн ирцтэйгээр 16 цаг 27 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим, 14 цаг 25 минут

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг эрье ээ. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн байгаа тул Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Дамдины Цогтбаатар, Ганибалын Амартүвшин гишүүн, Норовын Алтанхуяг гишүүн, Дашидондогийн Ганбат гишүүн, Цэндийн Мөнх-Оргил гишүүн, Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн, Шатарбалын Раднаасэд гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Цэдэвийн Сэргэлэн гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн хуралд хүрэлцэн ирсэн байна. Ингээд 52 хувийн ирцтэйгээр ирц бүрдсэн байна. Ингээд Байнгын хорооны гишүүдийн ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр хэлэлцэх 5 асуудал байгаа. Эхний асуудал бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 10 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

2 дахь нь, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн

газар 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

3 дугаар асуудал. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа нарын 19 гишүүн 2023 оны 12 дугаар сарын 8-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/-ийг хэлэлцэнэ.

4 дэх асуудал. “Шүүх байгуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа.

5 дугаар асуудал. “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 1 дүгээр сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа.

Ингээд хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу. Саналаа өгнө үү. Алга байна. Хэлэлцэх асуудлыг тэгвэл баталлаа. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

1 дүгээр асуудал. Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийе.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил танилцуулна. Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа, Улсын Их Хурал 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргилоор ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг, Ц.Мөнхцэцэг, Пүрэвдорж, Раднаасэд нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бөгөөд ажлын дэд хэсэг 8 удаа, ажлын хэсэг 2 удаа тус тус хуралдлаа.

Ажлын хэсгээс уг хуулийн төсөлд дараах өөрчлөлтийг оруулахаар санал оруулж байна. Үүнд:

Нэг.Сэжигтнийг хойшлуулиггүйгээр баривчлах зохицуулалтын талаарх санал:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах гэсэн 31.5 дугаар зүйлийг сэжигтнийг хойшлуулиггүйгээр баривчлах болгон бүхэлд нь өөрчлөн найруулах Засгийн газрын саналыг дэмжиж, зарим

өөрчлөлтүүдийг оруулж байна. Энэ зүйл 12 хэсэгтэй байх бөгөөд 1 дэх хэсэгт Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт холбогдуулан сэжигтнийг хойшлуулиггүйгээр баривчилж болох 3 үндэслэлийг тусгалаа. Одоо бол 6 үндэслэл байгаа. Үүнд:

1.Гэмт хэрэг үйлдэж байх үед, эсхүл үйлдсэнд дорно, эсхүл гэмт хэрэг үйлдсэн газраас зугтах үед барьсан,

2.Гэмт хэрэг үйлдсэн даруй гэрч, хохирогч шууд заасан,

3-д хэргийн газарт болон тухайн хүний хувцас, бие, орон байр, эд зүйл, тээврийн хэрэгсэлд ул мөр илэрсэн.

Харин 2 дахь хэсэгт Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэгт холбогдуулан сэжигтнийг дээр заасан 3 үндэслэлээс гадна хэн болох нь тогтоогдоогүй, Монгол Улсад оршин суух газрын хаяг тодорхойгүй, эрхэлсэн ажилгүйн улмаас түүнийг мэдэгдэх хуудсаар дуудах боломжгүй, эсхүл Монгол Улсад байнга оршин суудаггүй гэсэн 3 үндэслэлийн аль нэг нь тогтоогдвол шүүхийн шийдвэргүй баривчилж болохоор өөрчиллөө.

Мөн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүнд гэмт хэрэг үйлдэгдсэн даруй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад үндэслэл бүхий сэжиг тогтоогдвол сэжигтнийг энэ хуулийн 31.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр хойшлуулиггүйгээр баривчилж болохоор өөрчлөн найрууллаа. Ийнхүү сэжигтнийг хойшлуулиггүйгээр баривчлах үндэслэлүүдийг нарийвчлан тодорхойлж, практикт баривчлах үндэслэлийг субъектив хандлагаас хамаарч харилцан адилгүй хэрэглэж байгаа асуудлыг нэг мөр зохицуулах ач холбогдолтой юм.

Мөн сэжигтнийг хойшлуулишгүйгээр баривчлах ажиллагаанд прокурор хяналт тавих, мөрдөгчийн тогтоолыг батлах, шүүхэд даруй хүргүүлэх, эсхүл тогтоолыг үндэслэлгүй гэж үзвэл батлахаас татгалзах тухай шийдвэр гаргах, шүүх уг асуудлыг хянан шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан тусгасан өөрчлөлтүүдийг оруулаа. Ийнхүү хойшлуулишгүйгээр явагдсан баривчлах ажиллагааны үндэслэл үр дүнг хянуулахаар холбогдох материалыг шүүхэд хүргүүлснээр баривчлах ажиллагаанд тавих шүүхийн хяналтыг сайжруулж, мөрдөн шалгах ажиллагаанд хүний эрхийн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх чухал механизм болно гэж үзэж байна.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын дур зоргоор саатуулах асуудал эрхэлсэн хорооны гаргасан урьдчилсан дүгнэлтэд сэжигтэн, яллагдагч мэдүүлэг авах ажиллагаанаас гарах эрхгүй буюу мөрдөгчийн хяналтад орсон цаг мөчөөс эхлэн саатуулагдсан гэж үзнэ гэж хуульчлах нь зүйтэй гэсэн саналыг тусгасан. Олон улсын сайн туршлагаас харахад баривчилсан сэжигтнийг шүүхэд хүргэх хугацааг нарийвчлан зааснаас гадна уг хугацааг хэтрүүлсэн тохиолдолд хууль зүйн хариуцлага хүлээлгэдэг. Мөн хугацааг тодорхой заагаагүй боловч даруй шаардлагагүй хугацаа алдахгүйгээр хамгийн ойр байгаа шүүхэд эсхүл захиргааны ажилтанд хүлээлгэж өгөхөөр хуульчилсан нь хүний эрхийн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм аа

Хоёр.Баривчлах цагдан хорих асуудлыг хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллын талаарх санал:

Хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих саналыг шийдвэрлэх шүүхийн харьяаллыг тухайлан хуульчлаагүй бөгөөд практикт

гэмт хэрэг гарсан газрын харьяалах шүүхээр эсхүл мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй байгууллагын буюу хэргийн харьяалаар, эсхүл Тагнуул, Авлигатай тэмцэх газрын харьяаллыг хэрэгт хяналт тавьж буй прокурорын байгууллага оршин байгаа нутаг дэвсгэрийн харьяалаар баривчлах, цагдан хорих асуудлыг шүүх хянан шийдвэрлэж байна.

Дээр дурдсан нөхцөл байдал нь зарим тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэргийг уг хэрэг гарсан газрын харьяалах шүүх хянан шийдвэрлэнэ гэсэн нийтлэг зарчимд нийцэхгүйгээс гадна сэжигтнийг баривчлах, цагдан хорих зөвшөөрөл олгох шүүхийн харьяаллыг шүүхийн практикт өөр өөрөөр тайлбарлаж хэрэглэх, оролцогч шүүхийн харьяалалтай холбогдуулан шүүгч, шүүхээс татгалзан гарах зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүндрэл учруулах нөхцөл байдлыг бий болгож байна.

Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.1 дүгээр зүйлд заасан үндэслэлээр сэжигтнийг баривчлах тохиолдолд прокурорын саналыг гэмт хэрэг гарсан газрын харьяалах шүүх, сэжигтнийг шүүхийн шийдвэргүй баривчилсан тохиолдолд саналыг тухайн баривчлах ажиллагаа явагдсан газрын харьяалах шүүх, хэрэв баривчлагдсан сэжигтнийг 24 цагийн дотор уг хэрэг гарсан газрын харьяалах шүүхэд хүргэх боломжгүй бол баривчлах ажиллагаа явагдсан газрын шүүх хянан шийдвэрлэхээр өөрчиллөө.

Ийнхүү сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих саналыг шийдвэрлэх, шүүхийн харьяалааг шийдвэрлэх, шүүхийн нарийн харьяаллыг нарийвчлан тогтоосноор сэжигтэн, яллагдагчийн шүүхэд хандах эрхийг хамгийн богино хугацаанд шуурхай хангах боломж бүрдэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа цаашид хэвийн явагдах нөхцөлийг нөхцөл хангагдах юм.

Гурав.Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний талаар:

Мөрдөгч яллагдагчийг үргэлжлүүлэн цагдан хорих тухай саналаа хугацаа дуусахаас 7-оос доошгүй хоногийн өмнө прокурорт хүргүүлэх, прокурор цагдан хорих хугацааг сунгах тухай саналаа даруй шүүхэд хүргүүлэх, шүүх прокурорын саналыг хугацаа дуусахаас 4-өөс доошгүй хоногийн өмнө хянан хэлэлцэж, цагдан хорих хугацааг сунгах эсхүл сунгах, татгалзах тухай шийдвэр гаргах зохицуулалтыг тусгалаа.

Ийнхүү цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг сунгах процессыг нарийвчлан тодорхойлсноор прокуророос яллагдагчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг сунгах саналаа хугацаа дуусахаас өдөр цагийг нь тулгаж шүүхэд ирүүлснээс болж шүүхийн практикт хэлэлцүүлгийг товлон зарлах бусад оролцогчийг дуудан ирүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсдэг явдлыг хязгаарлах ач холбогдолтой юм.

Шүүхийн шатад яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдааныг хойшлуулах, түдгэлзүүлэх, хэргийг прокурорт буцаах, харьяалах шүүхэд шилжүүлэх зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой шийдвэр гаргах тохиолдол бүрд шүүгдэгчид урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг хэрхэхийг давхар шийдвэрлэх шаардлага үүсдэг бөгөөд эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүгдэгчид урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, хугацааг нь сунгахад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгод нийцүүлэн хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж дуусах хүртэл цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авч болох зохицуулалтыг тусгалаа.

Ийнхүү яллагдагчийг цагдан хорих хугацааг тоолох хугацааг нарийвчлан тогтоож өгснөөр шүүхийн шатад шүүгдэгчийг цагдан хорих хугацаанд яллагдагчийг цагдан хорих нийт хугацаанд орох эсэх нь тодорхойгүй байсан асуудлыг нэг мөр шийднэ.

Дөрөв.Бусад өөрчлөлтийн талаар:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар сэжигтэн гэм буруугаа хүлээхээс өмнө өмгөөлөгч авах эрхийг хүлээн зөвшөөрдөг бөгөөд баривчлах ажиллагаа явуулж буй албан тушаалтнууд баривчлагдсан этгээдэд хэрэг шийдвэрлэх ажиллагааны явцад эдлэх бүрэн эрхийг нь буюу Мирандын эрх гэж нэрлэгддэг. Мэдэгдэх хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг мөрдөгч сэжигтнийг баривчлах үед түүнийг ямар хэрэгт холбогдуулан баривчилж байгаа талаар мэдэгдэж, энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан хүнийг баривчлах үед түүнд баривчилсан шалтгаан үндэслэлийг мэдэгдэж өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, шүүхэд гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг сануулна гэж өөрчиллөө.

Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн баривчлах хугацааг тоолох 31.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт сэжигтнийг мөрдөн шалгах байгууллагад хүргэх, зайлигүй эмнэлгийн туслалцаа үзүүлэх, эрүүлжүүлэх, өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзахад зарцуулсан хугацааг энэ хуулийн 31.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан шүүхийн зөвшөөрлөөр баривчилж саатуулах хугацаа 48 цагаас хэтэрч болохгүй хугацаанд оруулан тооцохгүй байхаар нэмж тусгалаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар 15 зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг бэлтгэсэн.

Түүнчлэн “Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатын шүүхийн шүүгч Л.Галбадар, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх М.Чимэддорж, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Х.Буянтүмэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тэргүүн дэд дарга Ч.Оюунцэцэг, Цагдаагийн ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албаны дэд дарга, цагдаагийн хурандаа Б.Батсуурь, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын дарга Д.Энхтөр, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын ахлах мөрдөгч В.Баасанхүү, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хууль

тогтоомжийн хэлтсийн дарга Э.Бадамсамбуу, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Монголын Криминологичдын холбооны удирдах зөвлөлийн дарга, доктор, профессор Б.Батзориг, Монголын Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Л.Данзанноров, Монголын Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч асан, өмгөөлөгч Д.Батсүх гэсэн бүрэлдэхүүнтэйгээр оролцож байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Ажлын хэсгийн сая уншиж танилцуулсан танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Ганбат гишүүнээр тасаллаа. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Байнгын хорооны эрхэм дарга, гишүүддээ шинэ оны бас мэнд хүргэж, Хууль зүйн байнгын хорооны анхны хуралдаанаар Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ажлын хэсэг бас өнгөрсөн хугацаанд шуурхай ажиллаж, ажил хэрэгч олон санал, санаачилга гаргасанд талархлаа илэрхийлье.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг бол Монгол Улсын Засгийн газраас миний хувьд Хууль зүйн сайдаар томилогдоод 10 хоногийн дараа Засгийн газраар хэлэлцүүлж, 14 хоногийн дараа Улсын Их хуралд өргөн барьж шуурхай хэлэлцэхийг нь Улсын Их Хурал бас дэмжиж, шийдвэрлэсэн. Яагаад ийм хурдан, богино хугацаанд энэ асуудал хуулийн төсөл болж, парламентын гал тогоонд орж ирсэн бэ гэхээр энэ бол шинэ зүйл байгаагүй. Өнгөрсөн 10, 20 жилийн хугацаанд эрүүгийн хэргийг мөрдөх, хянан шийдвэрлэх ажиллагаанд

олон удаа яригдсан ийм асуудлууд дээр өмнө нь Хууль зүй, дотоод хэргийн яам дээр байнгын ажиллагаатай ажлын хэсгийн түвшинд санал боловсруулчихсан судалгаа нь хийгдсэн байсан. Ийм концепц. Ер нь гэмт хэргийг бид илрүүлэх, мөрдөх ажиллагаа эхнээсээ дуустлаа хууль, тогтоомжийн хүрээнд явагддаг байх ёстой. Хүний эрхийг хангасан түвшинд явагддаг байх ёстой.

2015 оны эрүүгийн процессын хууль, 2017 оны эрүүгийн процессын өөрчлөлтүүдээр энд байнга шат ахиж явж байгаа. Тэгэхдээ бид өнгөрсөн хугацаанууд дээр дүгнэлт хийгээд, энийг дахин урагш ахиулах чиглэлд бас өөрчилж гэсэн. Ялангуяа одоо заавал хорьж мөрдөхгүйгээр хүнийг шалгах энэ дадал энэ хууль сэтгэлгээнд хууль сахиулагчид өөрсдөө суралцах ёстой. Энийг бүр дадал болгох ёстой байгаад байгаа юм. Энэ дээр нь хууль тогтоогчид хууль санаачлагчид өөрсдөө манлайлал үзүүлж эрх зүйн реформыг нь урагшлуулж шийддэг байх ёстой.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын дүгнэлт гарсан. Монгол Улсад энэ дур зоргын баривчилгаа, цагдан хорио шүүхийн хяналтгүйгээр явагдаж байна гэдэг дүгнэлт. Бид нэгэнт энэ дүгнэлт гарсан учраас энэ дүгнэлтэд нухацтай, ажил хэрэгчээр хандах шаардлага байсан. Тийм ч учраас энэ дүгнэлтийг бид 100 хувь хүлээж авч, олон улсын хүний эрхийн байгууллагуудын зөвлөмж, манай гол судлаачид, байгууллагуудын зөвлөмж, энийг үндэслэж энэ хуулийн өөрчлөлт орж ирсэн юм.

Тэгэхээр би ажлын хэсгийн Батцэрэн шүүгч, судлаач Батзориг нараас асуух гэж байгаа юм. Энэ бол нэлээн томоохон хэмжээний өөрчлөлт болж байгаа. Манай энэ хууль сахиулах байгууллагын системийн хэмжээнд доргио өгөхүйц өөрчлөлт болж байгаа. Тэгэхээр хууль сахиулах байгууллага маань энд бэлэн байна уу. Ялангуяа хууль хэрэгжүүлэх хугацаан дээр энэ ажлын

хэсгийн танилцуулгаас харсан Дээд шүүх нэг журам гаргана гэсэн. Тэрийг нь дарчихсан байна. Хасаж байгаа юм байна ажлын хэсгийн саналаар. Хууль зүйн сайд бол нэг журам гаргана. Хууль зүйн сайд журам гаргах асуудал нь бол юу вэ гэхээр энэ Өмгөөлөгчдийн холбооны саналыг үндэслээд нэг журам гаргах юм. Яах вэ, энд хугацаа хэрэгтэй байгаад байгаа. Би дараа нь горимын санал гаргана. Энэ өмгөөлөгч энэ нөгөө хууль зүйн туслалцааны төв дээр би 2024 оны төсөв дээр 24 өмгөөлөгчийн төсөв батлуулсан. Тэгээд энэ өмгөөлөгчтэй сонгон шалгаруулах ажил одоо хийх гэж байгаа байхгүй юу. Тэгээд энд нэг жоохон хугацаа хэрэгтэй байгаад байгаа юм. Тэгэхээр шууд хэрэглэх дээр энэ Өмгөөлөгчдийн холбоо бас танай саналыг үндэслэж би журам батлах учраас Өмгөөлөгчдийн холбоо бас энд бэлэн үү гэсэн ийм асуултыг.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Данзанноров дарга хаана сууж байна. 3 дугаар микрофон өгье. Эхлээд 5 дугаар микрофон өгье. Тэгээд 3 дугаар микрофон.

Б.Батцэрэн: Та бүхний энэ өдрийг амгаланг айлтгая. Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Батцэрэн. Хууль зүйн сайд Энхбаярын асуултад хариулъя. Эрүүгийн процесс ажиллагааны хууль бол батлагдсан үеэсээ шууд дагаж мөрдөгддөг. Эрүүгийн процессын хуулийг бол буцааж хэрэглэдэггүй ийм онцлог бий. Тэгэхлээр энэ хуулийг баталж, хүчин төгөлдөр мөрдөхийн тулд тодорхой бэлтгэл ажиллагааг бол зайлиггүй хангах шаардлагатай.

1 дүгээрт хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх хүрээнд хууль хэрэгжүүлэгч нарт сургалт зохион байгуулах зайлиггүй шаардлага байгаа.

2 дугаарт баривчлах, цагдан хорих арга хэмжээг шүүх өдөр бүр амрах

зайлишгүй шаардлагатайгаас бусад цагт тасралтгүй хэрэгжүүлэх ийм заалт бол хуулийн төсөлд тусгагдсан. Үүнтэй холбоотойгоор анх Засгийн газраас өргөн барьсан хуулийн төсөлд бол энэ журмыг Улсын Дээд Шүүх баталж хэрэгжүүлэхээр заасан байсан. Ингээд Хууль зүйн байнгын хорооны дэргэд ажлын хэсэг хэлэлцээд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хүчин төгөлдөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулна гэсэн энэ зарчмыг 1 дүгээрт баримталъя. Зохицуулах шаардлагатай тийм зүйл байгаа бол энэ хуулиараа зохицуулъя. Харин шүүхийн захиргааны байгууллага энэ ажлын бус өдрүүдэд шүүх хуралдааны бэлтгэлийг хангах, прокурорын саналыг хүлээн авах, шүүхийн шийдвэрүүдийг албажуулах гэх мэт энэ асуудлыг бол эрүүгийн хэргийн хөдөлгөөний стандарт гэдэг энэ баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хэрэгжүүлэх боломжтой гэсэн ийм байдлаар хэлэлцээд хуулийн төсөлд бол өөрчлөлт оруулсан. Тийм учраас Шүүхийн ерөнхий зөвлөл энэ хэргийн хөдөлгөөний стандартад нэмэлт, өөрчлөлт оруулахад бол тодорхой цаг хугацаа бол хэрэгтэй байна.

3 дахь асуудал бол өмгөөлөгчийг томилж оролцуулах журмыг Өмгөөлөгчдийн холбооны саналыг харгалзан хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар хуулийн төсөлд тусгагдсан байгаа. Тэгэхээр энэ жижүүрийн өмгөөлөгч нарын ажиллах журам тэгээд шаардлагатай орон тоо, төлбөр гэх мэт энэ асуудлыг бол зайлишгүй журам гаргаж хэрэгжүүлэх ийм шаардлага үүсэж байна. Тэгээд энэтэй холбоотой бэлтгэл ажил зохион байгуулалтын арга хэмжээнүүд авах шаардлагатай учраас хуулийн хэрэгжилтийг бол ердийн журмаар биш энд бол тодорхой, одоо хугацаа зайлишгүй хэрэгжих хугацааг нь тусгайлан заах шаардлагатай гэж үзэж байна.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон.

Л.Данзанноров: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Тэгээд ажлын хэсгээс энэ нэмэлт, өөрчлөлтийн төсөл дээр өмгөөлөгч томилон ажиллуулахтай холбоотой асуудлыг өмнөх төсөл дээр бол хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар тусгагдсан байсан. Ярилцаж байгаад ямар ч байсан Өмгөөлөгчдийн холбооны саналыг харгалзъя гэсэн энэ асуудал дээр тогтсон байгаа. Гэхдээ журам батлах, журамтай холбоотой санал гаргаж ажлын хэсэг ажиллах, тухайн журмыг нэлээд бас өмгөөлөгч нартаа таниулах дээр бас тодорхой хугацаа шаардлагатай гэж бидний хувьд үзэж байгаа. Яагаад вэ, гэхээр тухайн журам боловсруулахтай холбоотой, таниулахтай холбоотой шаардлагатай үед зарим сургалтуудтай холбоотой асуудлууд гарах учраас хууль хэрэгжүүлэх хугацааг нь бас ердийн журмаар биш тухайн нэмэлт, өөрчлөлтдөө хэрэгжүүлэх хугацааг тусгайлан заах нь зүйтэй гэж үзэж байгаа. Яг ердийн журмаар гэх юм бол яг тодорхой бэлэн биш байдалтай байгаа гэж бас ойлгож болно.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүний микрофоныг өгье. Батзориг даргын микрофон 6 дугаар микрофон.

Б.Батзориг: Хууль зүйн ухааны доктор, профессор Батзориг. Энэ эрүүгийн процессын хуульд орж байгаа энэ 3 өөрчлөлт нь харахад их энгийн боловч яг хүний эрхийн хязгаарлалт тогтоох, ялангуяа Нэгдсэн Үндэсний Байгууллагын анхааралд орчихсон ийм том асуудал байгаа. Энхбаяр сайд хэлж байна. Яг зөв. Өөрөөр хэлбэл хэрэг шалгадаг арга сэтгэлгээ бүхэлдээ өөрчлөгдөхгүй бол хэчнээн хууль батлагдаад засрахгүй. Яагаад вэ гэхээр энэ 3 төрлийн өөрчлөлт орсноороо шүүх, прокурор, мөрдөх байгууллагуудын үйл ажиллагааг хооронд нь уялдуулах

шаардлага зайлиггүй гарч ирнэ. Түүнээсээ гадна ялангуяа баривчлах ажиллагааны явцад энэ хүний эрхэнд халддаг хууль сахиулах байгууллага, мөрдөх байгууллага руу шилждэг тийм шилжилтийн үеийн процессыг нэлээн уялдуулж өгөхгүй бол энэ хууль яг л хуучин шигээ хэрэгжээд явчих ийм эрсдэлтэй. Яах вэ, Авлигатай тэмцэх газар, Тагнуул бол харьцангуй цэгцрээд явчхаж болох байх. Хамгийн их том ачаалал энэ цагдаагийн байгууллага дээр очно. Яагаад гэхээр хүнийг саатуулах, баривчлах ажиллагааны явцад сумын хэсгийн цагдаагийн байранд яг хүнийг яг энэ хуульд заасны дагуу баривчилдаг, саатулдаг стандартын байр барихаас авхуулаад тэрийг аймаг дээр хүргэхээс авхуулаад аймаг дээр хүргэсний дараагаар прокурортоо танилцуулах, тэр шүүх хуралдаан эхлүүлэх гээд дэд бүтцийн нэлээн асуудлуудыг шийдэж өгөхгүй бол энэ хууль маань өөрөө хэрэгжээд эхлэхээрээ өөрөө энэ ярьж байгаа 3 асуудал ямар нэгэн алдаа гарах юм бол шууд мөрдөгч, прокурор, хууль сахиулах байгууллагын ажилтнууд эрүүгийн хэрэг үүсгээд шалгагдах их эрсдэлтэй.

Дээрээс нь сэтгэлгээ нь сургалтаасаа гадна энэ мөрдөх байгууллагууд дээрээс нь яг гэмт хэрэгтэй тэмцдэг хэв журам сахиулдаг байгууллагуудын өөрөөр хэлбэл зөрчил гэмт хэрэг 2 маань хоорондоо маш богино хугацаанд шилжиж өөрчлөгддөг. Гэмт хэрэг гээд бариад авсны дараа зөрчил болж хувирдаг, зөрчил болж байгаа нь гэмт хэрэг болж хувирдаг. Энэ шилжилтийг бол тодорхой хэмжээгээр энэ процессын хууль дээр оруулсан боловч хэрэгжих нөхцөлийг нь бүрдүүлэхгүй бол ялангуяа энэ хууль сахиулагч нар дээр, прокурорууд дээр, шүүхүүд дээр ачаалал бий болох байх. Тэгэхээр энэ дээр хууль тогтоогч та бүхэн хэрэгжих боломжийг нь бас сайн хангаж өгөх талаас анхаарч өгөөч ээ гэж хүсэлт тавьж байгаа юм.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Та бүхэнд шинэ оны мэнд хүргэж, бүгдийнх нь амар амгаланг айлтгая. Ингээд бид нар юу яадаг л даа, ингээд Эрүүгийн хууль Эрүүгийн хянан шийдвэрлэх хуулиараа ингээд ямар нэгэн өөрчлөлт хийгээд явдаг. Тэгээд үр дүнг нь ингээд хүлээдэг л дээ хүмүүс. Ямар нэгэн үр дүн гарах байх гээ. Тэр болгон тэр санасан үр дүн гардаггүй ээ. Тухайлбал энэ баривчлах, хорих дээр бас хэдэн юм хэлмээр байгаа юм.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын зохих хүмүүс нь ирээд, энэ баривчлан хорьсон асуудалтай танилцаад тэгээд тэр дүгнэлт нь гарсан байсан. Бараг 70, 80% нь шүүхийн шийдвэргүйгээр баригджээ гэж. Тэгээд бид нар чинь ардчилсан улс оронд хүний эрх гэж яриад байдаг. Энэ шүүхийн шийдвэргүйгээр ингээд яваад байж хууль нь бол байсан байгаад байгаа. Гэтэл ингээд зөрчигдөөд яваад байдаг байж. Тэгээд бид нар бол нөгөө иргэд рүүгээ гэмтэй, буруутай, бядгүй улных энэ тэр гээд л эрх баригчид янз янзаар хэлээд л ингээд дайраад байдаг. Тэгээд хийх ёстой ажлаа хийгээгүй тэр хууль намаа мөрдөж ажиллаагүй хүмүүс дээр ямар арга хэмжээ авдаг юм бэ. Энэ хуулийн зохих зүйл заалт байна уу. Нөгөө талаар бол энэ косметик маягийн иймэрхүү өөрчлөлтүүд хийгээд ингээд явах уу. Ер нь одоо 20, 30 жил ингэж явлаа. Энэ олон үзүүлэлтүүдийг хараад байхад л бүгд л ухарч байна шүү дээ. Одоо ер нь манай цагдаа нар, мөрдөгчид, Авлигатай тэмцэх газар, өөр Тагнуул юу байдаг юм жосоохон ур чадвартай ажилламаар байгаа шүү дээ. Тэгээд ажиллаж байгаа арга барил энэ тэр бол нөгөө л тэр 60, 70-аад оны үеийн нөгөө тэр тоталитар дэглэм байх үеийнхээ тэр байрлалаар хорьдог, тэгж байж ажилладаг тийм л байдалтай байгаа. Гэхдээ энэ хүмүүст мөнгө төгрөгийг нь ч тавьж өгдөггүй, боломжтой ажиллах. Тэр цагдаа, тагнуул, энэ мөрдөгч нарт нь өөрсдөө гараад бензин тосоо хийгээд тэр хүмүүстэй очоод газар дээр нь очоод уулзчих энэ нөхцөл байдал энэ тэрийг нь

өөрөөсөө араас нь явдаг, уулздаг, барьдаг. Тэгэхгүй бол өрөөндөө дуудаад л хорих энэ юмаа түрүүнд барьдаг. Тэгээд харья л даа одоо. Энэ хууль хяналтын байгууллагууд иргэддээ аягүй эрх баригчдынхаа даалгавраар аягүй хурдтай ажиллах юм. Барих, хорих нөгөө үгээ хэлдэг үзэл бодлоо илэрхийлдэг хүнд ямар нэгэн юм нялзаагаад л аваачаад л шоронд хийчихдэг. Ингээд нөгөө талаасаа харья л даа. Тэр албан тушаал авлига энэ юмтай нэг их олигтой тэмцээд үр дүн гаргаж чаддаггүй. Хамаг юм тэнд л байна шүү дээ. Тэрэнд чинь л дургүйцсэн иргэд л гарч жагсаад л үгээ хэлээд байгаа. Нөгөө талаараа бол энэ юмаа яаж шийдээд байгаа юм бэ. Тэр Хөгжлийн банк, Нүүрсний сонсгол гээд энэ сонсголууд амжилттай явагдаад дууслаа. Ямар нэгэн дутагдалтай энээ тэрээ тал байгаа байх. Тэрний мөрөөр ямар арга хэмжээ авч байна. Энэ өөрчлөлтүүд яагаад орж ирэхгүй байна гэсэн ийм асуудлууд байгаа юм л даа. Энэ өөрчлөлтүүдийг хийхгүйгээр жирийн ард иргэдийнхээ юмыг чангалж байгаа ч юм шиг, сулруулж байгаа ч юм шиг энэ маягаар тоглоод байдаг. Нөгөө улс орныг тонон дээрэмдэж байгаа, луйвардаж байгаа албан тушаалтнууд ерөөсөө хүрдэггүй. Бүр сүүлдээ одоо энэ олон түмэн чинь туйлдаж байна шүү дээ. Бид нар болохоор татвар төлөгчдийн мөнгөөр засгийн газраа тэжээгээд л, хууль хяналтын байгууллагаа цалин цавыг нь өгөөд л боломжоороо ингээд байгаад байдаг. Энэ ер нь юундаа байдаг юм бэ. Энэ хүмүүсээс нь нэг нь бүгдийг нь.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Эхлээд Мөнх-Оргил гишүүн хариулъя. Тэгээд дараа нь ажлын хэсгээс бас нэмэх юм байвал нэмээрэй.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Тэр Нэгдсэн Үндэсний Байгууллагын илтгэгчийн илтгэлд дурдагдсан тоон дээр бас бид нар эргэж харах юм бас байгаа юм. Тэр хүн бас жоохон мэдээлэл дутуу авчихсан юм шиг байгаа юм. Ер нь

бол шүүхийн шийдвэргүй баривчилна гэдэг нь өөрөө хууль бус гэсэн үг бас биш шүү дээ. Тэр хүн болохлоор ерөөсөө бүх баривчилгаа нь хууль бус байсан юм шиг нэг талаас ойлгочихсон юм шиг байгаа юм. Одоо бид нар энэ Засгийн газрын өргөн бариад бид нар Засгийн газрын өргөн барьсныг дэмжээд явж байгаа гол зарчмын өөрчлөлт бол энэ хуульд заасан хойшлуулигүй тохиолдолд гэдэг тэр хойшлуулигүй гэдгээр л шүүхийн шийдвэргүй баривчлаад байсан байгаа байхгүй юу. Тэгэхээр тэрийг бол одоо бид нар энд нэлээн тодотгоод ийм ийм 3 тохиолдолд л хойшлуулигүйгээр шүүхийн шийдвэргүйгээр баривчилна шүү гээд тодотгоод өгчхөж байгаа юм. Эхлээд баривчлахдаа шүүхийн шийдвэргүй баривчилна гэдэг маань шүүхийн хяналтаас огт гадуур явчхаж байгаа гэсэн үг бас биш байгаа байхгүй юу. Шүүх тэр дээр чинь нөгөөдхийг чинь прокурор аваачаад шүүхдээ танилцуулна шүү дээ. Хойшлуулигүй ажиллагааны журмаар ийм ийм юм болоод энэ хуулийн үндэслэлээр ингээд шүүхийн шийдвэргүй баривчилчихлаа гэхлээр тэрийг шүүх эсвэл дэмжинэ, эсвэл хүчингүй болгоно. Тэгэхээр тэр бол шүүхийн хяналтад бол байж байгаа юм. Гэхдээ оруулж ирж байгаа Засгийн газрын оруулж ирсэн манай ажлын хэсгийг нь дэмжээд одоо та нөхдөөр санал хураалгах гэж байгаа юм бол энэ одоогийн эрүүгийн процессын хуулийн 35.1.2-т заасан хойшлуулигүй тохиолдол гэдгийг тодотгож өгч байгаа юм.

2-т тэр косметик өөрчлөлт үү гэж Ганбат гишүүн асууж байгаа. Энэ их чухал асуулт л даа. Тэгэхээр 2 арга байна л даа. Ерөөсөө бүхлээр нь ингээд цогцоор нь өөрчлөөд явах нэг арга. Энэ бол нэлээн цаг хугацаа авна. Энэ бол ялангуяа Эрүүгийн хууль, Эрүүгийн процесс дээр ийм цогц реформ хийнэ гэх юм бол бид нар ахиад 5, 10 жил бол нэлээн ноцолдох байх. Тэрийгээ ойлгоод, хэрэгжүүлээд явж байтал ахиад 5, 10 жил болно. Тэгэхлээр Засгийн газар ямар санал оруулж ирж байгаа вэ тэрийг нь

манай ажлын хэсэг дэмжиж байгаа вэ гэхээр ерөөсөө байгаа хууль дээрээ өөрчлөлтүүдээ хийгээд хийгээд явж байна. Сайжруулаад л явж байна. Тэгээд олон удаагийн сайжруулалт хийгээд одоо гарцаагүй энийг бүхэлд нь шинэчлэн найруулах хэрэгтэй болчихлоо шүү гэсэн үед нь шинэчлэн найруулга хийх нь зөв юм байна. Тэгэхгүй бол цоо шинээр юм хийх гэж хүлээсээр байтал энэ амьдрал дээр тулчхаад байгаа асуудлууд шийдэгдэхгүй байна гэдэг асуудал яригдаж байгаа юм.

Тэр тодорхой хэргүүд, тэр Хөгжлийн банк, нүүрсний хэрэгтэй холбоотой асуудлаар бол манай ажлын хэсэг, ажлын дэд хэсгийнхэн эд нар бол ерөөсөө яриагүй. Зөвхөн Засгийн газраас өргөн барьсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тэр хүрээнд л бид нар ярьсан учраас тэр асуудал дээр манай ажлын хэсгээс тайлбар өгөх бололцоо алга. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Тэгэхээр ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. 8 санал байж байгаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг одоо уншина аа.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1дэх заалтын 2.2 дугаар зүйлийн 10, 11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.Энэ хуулийн 31.4 дүгээр зүйлд заасан үндэслэлээр сэжигтнийг баривчлах тухай прокурорын саналыг уг

хэрэг гарсан газрын харьяалах шүүх хянан шийдвэрлэнэ.

11.Энэ хуулийн 31.5 дугаар зүйлд заасны дагуу сэжигтнийг хойшлуулиггүйгээр баривчилсан тухай мөрдөгчийн шийдвэрийг уг хэрэг гарсан газрын харьяалах шүүх, хэрэв баривчлагдсан сэжигтнийг 24 цагийн дотор уг хэрэг гарсан газрын харьяалах шүүхэд хүргэх боломжгүй бол баривчлах ажиллагаа явагдсан газрын шүүх хянан шийдвэрлэнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Н.Алтанхуяг, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд цаашид “ажлын хэсэг” гэх. Санал хураалт явуулья. Энх-Амгалан гишүүнд микрофоныг нь өгье.

Б.Энх-Амгалан: Яах вэ, энэ 1.1 дээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, оргон зайлсан гээд тэгээд саатуулдаг юм байгаа биз. Энэ 1.2, 1.3 дээр би нэг сүүлийн юман дээр нь тэр мэдээлэл байгаа гэдэг нэг үг байгаад байгаа юм. Тэр ойлгомжтой шүү дээ. Баримт материал байж байгаа бол, нотлох баримт байж байгаа тэгээд л цагдан хорино л биз. Мэдээлэл ирсэн гэдэг юмаар ингэж хорьж болохгүй шүү дээ. Жишээлбэл одоо ингээд сайт дээр гарсан мэдээлэл байна ч гэдэг юм уу, ийм мэдээлэл надад олдлоо ч гэдэг юм уу нэг ийм байдал...

Д.Цогтбаатар: Энх-Амгалан гишүүн ээ, энэ яг нөгөө хэлэлцэж байгаа энэ зүйлийн юу биш байна шүү дээ.

Б.Энх-Амгалан: Зөвхөн 1.1 дээр үү. Энэ нэг ийм юм байгаа юм. 1.2 дээр ийм юм байгаа юм. Энийг дараа нь та надад тодруулж өгөөрэй.

Д.Цогтбаатар: Ойлголоо. Саяын энэ уншиж танилцуулсан томъёоллоор, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулья. 81,8%-аар санал

дэмжигдлээ. Минийх эсрэг гарчихсан байх юм. Яах вэ дэмжигдсэн юм чинь.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 3.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “Шүүх энэ хуулийн” гэсний дараа “14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3, 1.5 дахь заалт,” гэж нэмж, 3.1 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Энэ томъёоллоор дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.Засгийн газрын гишүүн өөрийнхөө оруулж ирсэн юуг 81,8%-аар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 14.10 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “5 хоногийн өмнө” гэснийг “7-оос доошгүй хоногийн өмнө” гэж, 8 дахь хэсгийн “4 хоногийн өмнө” гэснийг “4-өөс доошгүй хоногийн өмнө” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 88,1%-аар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 14.10 дугаар зүйлийн Тайлбарыг доор доор дурдсанаар өөрчлөн найруулж, 11, 12 дахь хэсэг болгох:

“11.Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор, оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүгдэгчид урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, цагдан хорих хугацааг сунгахад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж дуустал цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.

12.Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад шүүгдэгчийг цагдан хорьсон хугацаа нь энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хугацаанд хамаарахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэж санал хураалт явуулъя. 72,7%-аар санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 17.2 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.Прокурор, мөрдөгч ялагдагчид энэ хуулийн 7 дугаар бүлэгт заасан эрх, үүргээс гадна дараах эрхийг тусгайлан танилцуулна:

6.1.Тухайн гэмт хэрэгт оногдуулахаар заасан эрүүгийн хариуцлагын төрөл хэмжээний талаар мэдээлэл авах;

6.2.Прокурорын санал болгосон эрүүгийн хариуцлагын төрөл хэмжээг хүлээн зөвшөөрөх эсвэл татгалзах;

6.3.Эрүүгийн хариуцлагын төрөл хэмжээний талаар өөрийн саналыг илэрхийлэх;

6.4.Шүүх шийдвэр гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэхээс татгалзах.

7.Прокурор хохирогчид энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шийдвэрийг мэдэгдэж, хохирол нөхөн төлөх талаар ялагдагчийн гаргасан санал болон энэ хуулийн 8 дугаар бүлэгт заасан эрх, үүргийг тусгайлан танилцуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэж санал хураалт явуулъя. 81,8%-аар санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 17.2 дугаар зүйлийн 8, 9 дэх хэсгийн “хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй” гэснийг “ердийн журмаар хянан шийдвэрлэнэ.” гэж тус тус өөрчилж, 11 дэх хэсгийн “Эрүүгийн хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэсэн нь” гэсний дараа “мөрдөн шалгах ажиллагааны явцад” гэж нэмж, 17.2 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэж санал хураалт явуулъя. 90%-ийн хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 17.3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5.1 дэх заалтын “тохиролцоо хийгдсэн огноо” гэснийг “прокурорын санал танилцуулсан он, сар, өдөр” гэж өөрчилж, 17.3 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.Прокурор яллах дүгнэлтийн хувийг яллагдагчид гардуулж, хавтаст хэргийг харьяалах шүүхэд шилжүүлсэн тухай яллагдагч, хохирогч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч өмгөөлөгчид мэдэгдэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэж санал хураалт явуулъя. Санал хураалтыг түр зогсооё. Энх-Амгалан гишүүний микрофоныг өгье.

Б.Энх-Амгалан: Энэ яллах дүгнэлт үйлдээд л тэгээд л шууд гардуулчихаад л эсвэл одоо яллах дүгнэлт үйлдчихээд л шүүхэд шилжүүлчихээд л. Тэгээд тэрнийхээ дараа энэ хууль ёсных нь төлөөлөгч, өмгөөлөгч энэ тэрт мэдэгдэнэ гэж ямар юм байдаг юм бэ. Наана нь мэдэгдэж тэр хэрэгтэй нь танилцуулаад, тэр өмгөөлөгч, тэр хууль ёсных нь хүмүүс нь үзэж харж ингэж байж явахгүй тэгээд л чамд мэдэгдсэн, гүйцээ. Наадах чинь одоо шүүх дээр оччихсон гээд л ингээд л явах нь байна шүү дээ. Эзэн нь өөрөө шүүх дээр очоогүй байхад хэрэг нь шүүх дээр оччихдог юм байна лээ шүү дээ энэ чинь. Ингэж цаашаа явбал энэ чинь өөрөө их аюултай юм байна лээ шүү дээ. Энийг заавал тэр өмгөөлөгч нь өөрөө байлцаж байж өмгөөлөгч ирээгүй бол тэр шүүхэд шилждэггүй байх юмыг нь хийхгүй бол энэ чинь тэгээд боогоод шидчихдэг юм байна лээ шүү дээ. Тэгэхээр энийг жоохон анхаарах хэрэгтэй. Яг энэ заалт дээр бол би эсрэг байр суурьтай байна. Энийг жоохон найруулдаг юм уу, яадаг юм.

Д.Цогтбаатар: Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Энд Засгийн газраас өргөн барьсан, манай ажлын хэсгээр дэмжигдээд явж байгаа ерөөсөө үндсэн суурь санаа бол Энх-Амгалан гишүүн ээ, эрүүгийн хэрэг үүсгэснээс эхлээд ер нь баривчилснаас эхлээд л бүх шатад өмгөөлөгчийн оролцоотой байгаа. Ерөөсөө өмгөөлөгчийн оролцоогүй нэг ч үйл ажиллагаа байхгүй болсон. Өөрөө өмгөөлөгчтэй өмгөөлөгч нь ирж чадаагүй бол улсын өмгөөлөгч баривчилгаанд нь оролцоно. Анхны мэдүүлэг авахад нь оролцоно. Мэдээж яллах дүгнэлт эд нар гаргахад нь бол ерөөсөө бүгд өмгөөлөгчтэйгөө л оролцоно. Засгийн газрын өргөн барьсан хувилбар нь ийм байсан юм. Прокурор хэргийг хэзээ, аль шүүхэд шилжүүлсэн талаар яллагдагч, түүний өмгөөлөгч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ гэж байсан байхгүй юу. Хэнд одоо хэрэг чинь хаашаа явсан бэ гэдгээ хэлнэ гэж байсан юм. Энийг нь бид нар бүр тодотгоод прокурор, яллах дүгнэлтийн хувийг яллагчид гардуулж, хавтаст хэргийг харьяалах шүүхэд шилжүүлсэн тухай яллагдагч, хохирогч эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэнэ гэж байгаа юм. Үүний чинь өмнө нөгөө хавтаст хэрэгтэй чинь өмгөөлөгчөө өөрийг нь бүгдийг нь танилцуулаад хуулбарлах, асуулт асуух, хувилж авах эрхийг нь бүгдийг нь нээгээд, тэр бүх процесс явагдчихаж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бол яллагдагчийн эрхийг нэмж өгч байгаа асуудал. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Энх-Амгалан гишүүн хариулт хангалттай юу. Тэгвэл дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Саяын 8 дугаар зүйлийг дахин уншаад хэрэггүй байх. 7 дугаар санал юм байна шүү. 90,9%-аар санал дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Ер нь 1 дүгээрт зүгээр ажлын дэд хэсэг, ажлын хэсгийн ажилласан горимыг танилцуулахад энэ Байнгын хороогоор санал хураалгаж байгаа зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг манай ажлын дэд хэсэг, тухайлбал, Дээд шүүх, прокурор, Хүний эрхийн Үндэсний Комисс, Өмгөөлөгчдийн холбооны төлөөлөгчдөөс бүрдсэн том ажлын хэсэг дээр нэгт нэгэнгүй ярилцаад, бүгд хүлээн зөвшөөрөөд энэ хуулийн зохицуулалтаар бол бид нар нэг талаас ажлаа хийж чадах юм байна, хүний эрхийг хамгаалах юм байна, нөгөө талаас гэмт хэрэгтэй тэмцэж чадах юм байна. Энэ тэнцвэрийг хадгалж чадсан зохицуулалт боллоо гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа юм. Энэ дээр бол сэтгэл бүр мэдээж 100% ханасан аль ч байгууллага байхгүй. Тэгэхдээ 100% сэтгэл хангалуун үлдээгүй аль ч байгууллага байхгүй. Энэ бол баланс барьсан 1 дүгээрт.

2 дугаарт энэ хураалгах гэж байгаа заалт дээр Засгийн газрын өргөн барьсан хуулийн төслийн 7.1 дүгээр зүйлийн 7 дахь заалтыг хассан. Энэ нөгөө Дээд шүүх журам батална гэсэн заалт байсан байхгүй юу. Тэгээд энийг бид нар ярьж байгаад түрүүн Батцэрэн шүүгч тайлбарлалаа. Тэгээд энэ Засгийн газрын өргөн барьсан хуулиас хасагдаж байгаа ерөөсөө цорын ганц заалт нь энэ. Тэгээд яагаад энэ дээр хасах ёстой болсон бэ гэхлээр 2 шалтгаан гарсан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгдөх журмын асуудал ярьж байвал энэ хуульчлагдах ёстой. Процесс хуульчлагдах ёстой. Хэрвээ энэ нөгөө нэг шүүх өглөө 06-22 цагийн хооронд ажиллах ёстой болж байгаа шүү дээ. Нөгөө баривчилгаа, цагдан хорихын шүүгч чинь. Тэгэхээр тэр цагдан хорихын шүүгч өглөө 06-22 цагийн хооронд ажиллах эрүүгийн процессыг нь Дээд шүүх зохицуулах гэж байгаа бол тэр бол болохгүй ээ. Тэр бол хуульчлагдах ёстой. Хэрвээ тэр 06-22 цагийн хооронд ажиллах захиргаа, логистик, байр сав гээд тэр асуудлыг ярих гэж байгаа бол

Шүүхийн ерөнхий зөвлөл шийдэх ёстой асуудал болчхоод байгаа байхгүй юу. Тэгээд энийг тал талаас нь ярьж байгаад энэ ерөөсөө явсаар байгаад шаардлагатай бол процесстoo нэмэлт, өөрчлөлт оруулъя. Одоогийнхоороо бол явж байхад хангалттай юм байна. Процесс талаасаа. Хэргийн удирдлага талаасаа бол Шүүхийн ерөнхий зөвлөлийн нөгөө эрүүгийн хэргийн удирдлагын менежментийн процессын нэг журам байгаа байхгүй юу. Тэр дотроо нэмээд оруулчихад хангалттай юм байна гэдэг үндэслэл гарсан учраас энэ заалтыг нь хасаж байгаа юм шүү. Энэ дээр бол бүгд санал нийлж байгаа юм.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Тэгэхээр бас нэг журамд бол өөрчлөлт орох л ёстой юм байна тийм үү. 4 дүгээр микрофон өгье.

Н.Баярмаа: Тийм. Эрүүгийн хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал гэдэг нь стандарт явдаг. Тэр дээр захиргааны ажилтан ажиллах, мэдээлэл лавлагаа хэргийг яаж хүлээж авах юм, 06-22 цагт яах юм, ирснийг нь хэрхэн 24 цагийн дотор зохион байгуулахыг гэдгийг Эрүүгийн хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал буюу энэ стандартдаа өөрчлөлт оруулж зохицуулах юм. Тэгээд Шүүхийн тухай хуульдаа энэ аргачлалыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална гэсэн эрх зүйн үндэс нь байдаг. Түүнийхээ дагуу ингээд олон жил явж байгаа. Түрүүн хэлсэнчлэн энэ хууль ердийн журмаар биш жосоохон хэрэгжих боломжит хугацаа өгөхөд тэр хугацаанд бол Шүүхийн ерөнхий зөвлөл энэ нийтлэг хөдөлгөөнийхөө стандартдаа өөрчлөлт оруулаад, шинэ хуулийнхаа өөрчлөлтөд нийцүүлээд явах бүрэн боломжтой.

Д.Цогтбаатар: Тэгвэл энэ дээр санал хураалтаа явуулчихъя. Тайлбарууд аваад дууслаа. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 70%-ийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Одоо энэ чинь ингээд төслийн 2 дугаар зүйл рүү орно. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Хүн байхгүй байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт. Энд нэг санал байна гэж байгаа шүү дээ. 2 дээр тийм санал хураалт байхгүй байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Энх-Амгалан гишүүн. Энх-Амгалан гишүүний микрофоныг өгье.

Б.Энх-Амгалан: Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 14.9 дүгээр зүйл. Энэ дээр би сая түрүүн хэлсэн. 1.1 бол оргон зайлахыг завдсан, оргон зайлсан гэдэг нь бол болж байна. 1.2, 1.3 дээр байгаа тэр мэдээлэл байгаа гэдэг үгээ хасчихмаар байна. Үндэслэл бүхий баримт байгаа, нотлох баримт байгаа гэдэг ойлгомжтой шүү дээ. Мэдээлэл байгаа гэдэг чинь бол өөрөө ингээд таслал тавиад мэдээлэл байгаа гэхихээр зэрэг тэр сайт дээр тийм мэдээлэл гарсан, энэ дээр ийм юм байсан, тэр хүн тэгж байсан ч гэдэг юм уу ийм нэг мэдээлэл байгаа гэдэг үг өөрөө их бүрхэг үг байхгүй юу. Тэгэхээр энэ мэдээлэл байгаа гэдэг үгийг энэ дээрээс хасчих ямар бололцоо, боломж байна вэ. Энэ дээр Өмгөөлөгчдийн холбоо ямар байр суурьтай байна. Энэ бол мэдээлэл гэдэг нь өөрөө их өргөн хүрээний ойлголт шүү дээ. Тэртээ тэргүй үндэслэл бүхий баримт байгаа гэдэг чинь энэ дотроо мэдээлэл нь орчхож байгаа байхгүй юу. Тийм учраас мэдээлэл байгаа гэдэг юмны мэдээлэл гэдэг үгийг хасчихмаар байх юм.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгийн даргад микрофон шилжүүлье. Мөнх-Оргил гишүүнд.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ одоо Эрүүгийн процесст яг байгаа заалт л даа. Үндэслэл бүхий баримт, мэдээлэл гээд. Тэгээд мэдээлэл гэж нөгөө юу шүү Энх-Амгалан гишүүн ээ. Энэ хэвлэлийн

мэдээлэл биш шүү. Хэвлэлийн мэдээлэл биш. Ер нь бол ингэж байгаа шүү дээ. Одоо бол цагдан хорихыг жишээ нь бүх төрлийн гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа яллагдагчид хэрэглэж байгаа байхгүй юу. Засгийн газрын өргөн барьсан, манай ажлын хэсгийн дэмжиж байгаагаар бол зөвхөн хорих ял оногдуулахаар гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа хүнд. Тэгэхээр чинь нэлээн хумигдаж байна.

2 дугаарт 06-22 цаг ажилладаг тусдаа шүүгчтэй болж байна.

3 дугаарт энэ цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэлүүдийг илүү об'ектив болгож өгч байгаа юм. Тэр дотор та бол одоо энэ мэдээлэл гэдэг чинь субъектив хандлагатай байна шүү дээ гээд. Тийм ээ. Тэгэхээр энэ дээр Цогтоо дарга аа, манай ажлын дэд хэсгийнхэнд микрофон өгөөд энэ эрүүгийн байцаан шийдэх хуульд энэ эрүүгийн процесст энэ мэдээлэл гэдэг үг яг ямар агуулгатай байдаг билээ. Яг хуулийн ямар заалттай билээ гэдгийг тайлбарлаад өгчихмөөр байгаа юм. Энэ мэдээлэл бол хэвлэлийн мэдээлэл биш. Энх-Амгалан гишүүн ээ.

Д.Цогтбаатар: 5 номерын микрофон өгье.

Б.Батзориг: Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Доктор, профессор Батзориг. Эрүүгийн процессын хуульд баримт таслал мэдээлэл гэсэн зохицуулалт 6 удаа байгаа. Энэ маань ямар тохиолдолд байгаа вэ гэхээр хүний амь нас, эрүүл мэндэд яг бодитой занал учирсан тохиолдолд, нөгөөх нь болохоор гэмт хэрэг яг одоо үйлдэгдэж байгаа тохиолдолд. Өөрөөр хэлбэл цагдан хорих үндэслэл дээр байгаа юм. Энэ маань өөрөөр хэлбэл бусад процессын юун дээр бол дандаа нотлох баримт шаардаж байгаа. Нотлох баримт шаардана гэдэг маань Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар бүлэгт заасан

нотолгооны стандартыг бүрэн хангаж байж шийдвэрийн үндэслэл болж байгаа. Энэ Энх-Амгалан гишүүний асууж байгаа баримт таслал мэдээлэл гэсэн энэ б хуулийн заалт нь яг одоо хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулах гэж байна. Яг одоо ийм гэмт хэрэг үйлдэгдэж байна гэдэг мэдээлэлд тулгуурлаж гаргаж байгаа шуурхай ажиллагааны стандартын шийдвэр. Өөрөөр хэлбэл нотолгооны стандартыг арай бага хангасан. Тэгээд энэ мэдээллийг бол цагдан хориотой холбоотой шүүхийн хэлэлцүүлгээр бас хэлэлцэж байж шүүх шийдвэрээ гаргах ийм үндэслэлтэй байгаа юм.

Д.Цогтбаатар: Өөр нэмж хариулах уу. Ажлын хэсгээс болсон уу.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 3 санал байгаа.

9.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 14.9 дүгээр зүйлийн нэг дэх хэсгийн “өөр төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авах боломжгүй гэж үзвэл” гэснийг хасаж, 1.1 дэх заалтын “оргон зайлсан” гэсний өмнө “эсхүл” гэж, 14.9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “саналыг үндэслэн” гэсний дараа “шүүх” гэж тус тус нэмж, 14.9 дүгээр зүйлийн 1.2 дахь заалтын “сүрдүүлсэн” гэснийг “эсхүл, сүрдүүлсэн, эсхүл нөлөөлсөн” гэж, 2.1 дэх заалтын “1.1, 1.3-т” гэснийг “1.1, 1.2, 1.3”-т гэж тус тус өөрчилж, 14.9 дүгээр зүйлийн 2.3, 2.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2.3, 2.4, 2.5 дахь заалт болгох:

“2.3.зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэрэг гэмт хэрэгт хамтран оролцсон;

2.4.Монгол Улсад оршин суух газрын хаяг тодорхойгүй, эрхэлсэн ажилгүйн улмаас түүнийг мэдэгдэх хуудсаар дуудах боломжгүй;

2.5.Монгол Улсад байнга оршин суудаггүй.” Санал гаргасан ажлын хэсэг.

Дэмжье гэж санал хураалт явуулъя. 80%-ийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 17.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн “талууд” гэснийг “прокурор” гэж, “тохиолдолд” гэснийг “үндэслэлээр” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэж санал хураалт явуулъя. 70%-ийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 31.5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“31.5 дугаар зүйл сэжигтнийг хойшлуулиггүйгээр баривчлах

1.Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт холбогдуулан сэжигтнийг дараах үндэслэлээр хойшлуулиггүйгээр баривчилж болно:

1.1.гэмт хэрэг үйлдэж байх үед, эсхүл үйлдсэн дор нь, эсхүл гэмт хэрэг үйлдсэн газраас зугтах үед нь барьсан;

1.2.гэмт хэрэг үйлдсэн даруй гэрч, хохирогч шууд заасан;

1.3.хэргийн газарт болон тухайн хүний хувцас, бие, орон байр, эд зүйл, тээврийн хэрэгсэлд ул мөр илэрсэн.

2.Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэгт холбогдуулан сэжигтнийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дараах үндэслэлийн аль нэг нь тогтоогдвол хойшлуулиггүйгээр баривчилж болно:

2.1.хэн болох нь тогтоогдоогүй;

2.2.Монгол Улсад оршин суух газрын хаяг тодорхойгүй, эрхэлсэн ажилгүйн улмаас түүнийг мэдэгдэх хуудсаар дуудах боломжгүй;

2.3.Монгол Улсад байнга оршин суудаггүй.

3.Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүнд гэмт хэрэг үйлдсэн даруй энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад үндэслэл бүхий сэжиг тогтоогдвол сэжигтнийг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан аль нэг үндэслэлээр хойшлуулиггүйгээр баривчилж болно.

4.Мөрдөгч сэжигтнийг хойшлуулиггүйгээр баривчилсан даруй прокурорт мэдэгдэж, прокурор баривчлах ажиллагаа хуульд нийцсэн эсэхийг хянаж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

4.1.мөрдөгчийн шийдвэрийг баталж, шүүхэд даруй хүргүүлэх;

4.2.мөрдөгчийн шийдвэрийг үндэслэлгүй, эсхүл үргэлжлүүлэн баривчлах шаардлагагүй гэж үзвэл батлахаас татгалзаж, тэмдэглэл үйлдэх.

5.Үндэслэлгүйгээр баривчлагдсан сэжигтнийг прокурор даруй суллана.

6.Мөрдөгч энэ хуулийн 30.17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлтэй бол хойшлуулиггүйгээр баривчилсан сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналаа сэжигтнийг баривчилснаас хойш прокурорт даруй хүргүүлнэ.

7.Прокурор мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл саналыг хүлээн авснаас хойш 6 цагийн дотор баривчилсан сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах эсэхийг шийдвэрлэнэ.

8.Прокурор сэжигтэн сэжигтнийг баривчилсан шийдвэрийг хүчинтэйд тооцуулах, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, хязгаарлалт тогтоох, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай саналаа баривчлах хугацаа дуусахаас 24 цагийн өмнө шүүхэд хүргүүлнэ.

9.Шүүх энэ зүйлийн 8 дахь хэсэгт заасан прокурорын саналыг хүлээн авснаас хойш даруй, эсхүл 24 цагийн дотор шүүхийн хэлэлцүүлгийг товлон явуулж, прокурорын саналыг үндэслэн баривчлах ажиллагааг хүчинтэйд тооцох, яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг хянан шийдвэрлэнэ.

10.Прокурор, эсхүл баривчлах байрны даргын шийдвэрээр суллагдсан сэжигтэн, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч уг хэрэг гарсан газрын харьяалах шүүхэд баривчлах ажиллагааны талаар сэжигтнийг суллагдсанаас хойш 10 хоногийн дотор гомдол гаргаж болно. Прокурор гомдол холбогдох материалыг харьяалах шүүхэд даруй хүргүүлнэ.

11.Шүүх энэ зүйлийн 10 дахь хэсэгт заасан гомдлыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор энэ хуульд заасан нийтлэг журмын дагуу шүүхийн хэлэлцүүлгийг товлон явуулж, баривчлах ажиллагааг хүчинтэйд тооцох эсэхийг хянан шийдвэрлэнэ. Энэ шийдвэрт гомдол гаргахгүй.

12 Энэ зүйлийн 10 дахь хэсэгт заасны дагуу суллагдсан хүн гомдол гаргаагүй бол холбогдох шийдвэрийг 30 хоногийн дотор харьяалах шүүхэд хүргүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэж санал хураая. Мөнх-Оргил сайдад микрофон өгье.

Ц.Мөнх-Оргил: Дарга аа. Энэ дээр нэг үг орхигдчихсон байна. Санал хураалгаж байгаа 31.5.6 дээр мөрдөгч энэ хуулийн 30.17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан аль нэг гэж үг орхигдчихож. Аль нэг үндэслэл байгаа бол хойшлуулиггүй баривчилсан сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах саналаа сэжигтнийг баривчилсан прокурор даруй хүргүүлнэ. 3 дээр заасан аль нэг үндэслэлээр аль нэг үндэслэлээр хойшлуулиггүй яваад явчхаж болно гээд.

Д.Цогтбаатар: Тэгвэл энэ төслийн 3.3 дахь хэсэг, 3 дахь хэсэг дээр тээ. Тэгвэл, тэгээд аль нэг гэсэн юуг оруулж уншсанд тооцоод тэгээд санал хураая. Зарчмын зөрүүтэй биш. Энэ чинь үг орхигдчихсон байна гэж байна шүү дээ. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Би 31.5-ын сэжигтнийг хойшлуулиггүйгээр баривчлах гэдгийн 1.3 дээр асуух гээд байна. Бид нар бол үндсэндээ аль болох л сэжигтнийг хойшлуулиггүйгээр баривчлахгүй байх л хүний эрхийг хангах үүднээс ингэх гэж байна. Тэгээд зайлиггүй тохиолдолд 3 тохиолдолд л хойшлуулиггүйгээр баривчлахаар болж байх шиг байна. Тэгэхээр тэр 1.3 дээр хэргийн газарт болон тухайн хүний хувцас бие, орон байр, эд зүйл, тээврийн хэрэгсэлд ул мөр үлдээсэн илэрсэн бол ул мөр гэдэг чинь өөрөө бас том баривчлах, хойшлуулиггүйгээр баривчлах тэр нэг үүд хаалгыг л нээж байна гэж бодоод байх юм. Би зайлиггүй нотлох баримт байгаа л бол зайлиггүй хойшлуулиггүйгээр баривчлах асуудал яригдах юм биш үү. Гэтэл одоо энэ чинь ул мөр илэрсэн гэдэг нэрийн дор л одоо хойшлуулиггүйгээр баривчлаад байх тэр үүд хаалга чинь бас нээлттэй үлдэх нь байна шүү дээ. Энэ дээр та бүхэн юу гэж үзэж байна вэ гэдгийг хариулж өгөөч. Энэ дээр Хүний эрхийн Үндэсний комисс ямар байр суурьтай байгаа юм. Өмгөөлөгч нар ямар байр суурьтай байгаа юм 1.3 дээр. Энийгээ нэг хэлж өгөөч.

Д.Цогтбаатар: Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Энэ одоогийн 31.5.1.4 дээрээ байгаа заалт юм аа. Угаасаа энэ ер нь тогтчихсон онолын ч болон практикийн үндэслэлтэй ийм зүйл ерөөсөө үндсэн санаа бол одоо жишээ нь хэргийн газарт өөрийнх нь хурууны хээ, цус, шүлс, эсвэл хувцсанд нь, орон байранд нь тухайн

гэмт хэргийн ул мөр үлдчихсэн, ул мөр дотор дахиад л тэр гэмт хэргийг үйлдсэн зэвсэг, зэмсэг, цус одоо юу байдаг юм тийм ээ, тухайн хохирогчийн эд хогшил ч байдаг юм уу энийг л хэлж байгаа юм. Тэгээд энийг чинь хойшлуулиггүйгээр баривчилчихаад заавал тэр нөгөө нэг нотлох баримт мөн байна. Энэ хүн яг гэмт хэрэг хийчихсэн нь бүр нотлогдох хэмжээнд аваачиж байж тэр хүнийг хойшлуулиггүйгээр баривчилсна гэх юм бол тэр хүн чинь яваад өгчхөж байгаа байхгүй юу. Одоо энийг чинь хойшлуулиггүйгээр баривчилчихаад, 48 цагийн дотор шүүх тэр хүнд чинь баривчилснаас хойш 24 цагийн дотор шүүх тэр хүнийг чинь суллах уу, үгүй юу. Хойшлуулиггүй баривчилсан нь зөв байж уу, буруу байж уу гээд дүгнэлтээ гаргачихна шүү дээ. Тэгээд тэрний дараа цуглуулсан баримтаа нотлох, шүүх дээр нотлох баримтын хэмжээнд хүргэх асуудал чинь нөгөө мөрдөн байцаагчийн чинь гол ажил болж байгаа байхгүй юу. Тэгэхээр нөгөө нөхрийг л оргон зайлуулахгүй байх л үндэс. Энэ дээр бол одоо шүүхийн практик, манай хууль хяналт, мөрдөгч нарын практик бол их тодорхой болчихсон юм байна лээ дээ. Энэ дээр миний хэлж байгаа дээр нэмээд Батцэрэн шүүгч тайлбар хэлчих үү. Практик дээр энэ ер нь яг яаж шийдэгддэг юм. Эндээс болж хүний эрх зөрчигдөж байгаа тийм асуудлууд их гарч байна уу. Батцэрэн шүүгч тайлбарлаад өгчих байх.

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон өгье. Дараа нь 2, 3 бас хариултаа бэлдчихээрэй.

Б.Батцэрэн: Баривчлах ажиллагаа шүүхийн шийдвэртэй болон шүүхийн шийдвэргүй явагдах ийм 2 өөр журам байгаа юм. Өнгөрсөн 3 жилийн баривчлах ажиллагааны талаар хийсэн судалгаанаас харахад нийт баривчилгааны 60-аас дээш хувь нь хойшлуулиггүй гэдэг ийм л үндэслэлээр баривчилж ирсэн. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль дээр шүүхийн

шийдвэргүй баривчлах 4 үндэслэл байдгийн 1 нь тэр хойшлуулиггүй үндэслэл. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 9 дүгээр зүйлийн албан ёсны тайлбарт хүнийг баривчлах, цагдан хорих үндэслэл ерөнхий байж болохгүй. Энэ их тодорхой байхгүй бол хүний эрхийн зөрчил гарах эрсдэлтэй гэж тайлбарласан байдаг. Тэгэхээр энэ нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд тэр хойшлуулиггүй гэдэг заалтыг бүхлээр нь байхгүй болгочхож байна. Дээр нь баривчлах ажиллагааг зөвхөн хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг дээр л хэрэглэнэ. Дээр нь энэ 3 үлдэж байгаа шалгуур бол гэмт хэрэг үйлдэж байх үед нь барьсан, эсвэл гэрч, хохирогч шууд заасан, гэмт хэрэг үйлдсэн даруйд нь, эсвэл гэмт хэргийн ул мөр илэрсэн энэ 3 шалгуур бол гурвуулаа объектив шалгуур. Объектив шалгуур. Тэгээд энийгээ шүүхийн өмнө очиж нотлох ёстой. Тэгж байж хуульд заасан үндэслэл журмын дагуу баривчлагдсан гэдэг энэ нөхцөл хангагдах юм байгаа юм. Тэгэхээр шүүх бол тэр цагдан хорих асуудлыг шийдэхээсээ өмнө энэ баривчлах ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдсан уу гэдэг дээр хууль зүйн дүгнэлт хийнэ. Баривчлах ажиллагааг хүчинтэйд тооцох эсэх асуудлыг шийднэ. Тэгэхээр энэ таны асууж байгаа тэр гэмт хэргийн ул мөр илрэх гэдэг бол яг объектив тодорхой ийм шалгуур учраас энэ дээр бол асуудал гарахгүй байх. Энэ урьд нь ч олон жил хүчин төгөлдөр үйлчилж ирсэн хуулийн бас заалт байгаа юм.

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон өгье.

Б.Энхболд: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Сандаг-Очир гишүүний асуусан энэ 35.1.3 буюу энэ ул мөр илэрсэн гэдэг энэ зохицуулалт бол одоогийн хууль дээр бол байдаг. Тэгэхдээ энэ бас бол эрсдэлтэй заалтад орж байсан ийм практик бол байдаг. Тэгэхээр энэ заалтыг яаж хаалт хийх вэ гэдэг асуудлыг бол ажлын хэсэг дээр бол

нэлээн нухацтай ярьсан. Тэгээд энэ дээр бол 3 хаалт орж ирж байгаа гэж харж байгаа.

1 дүгээрт нь, энэ зөвхөн хорих ялтай гэмт хэрэгт холбогдуулсан хэрэг дээр энийг шийдвэрлэж байж болно.

2 дугаарт энэ ажиллагаа шүүх дээр очиж заавал хянан хэлэлцэгдэж үнэхээр ул мөр бодитой байж уу, үгүй юу гэдгийг шүүх хянаж баривчлах ажиллагааг хүчинтэйд тооцох эсэх асуудлыг шийднэ.

3 дугаарт шүүх ингээд цаашаа үргэлжилчихсэн тохиолдолд 14 хоногийн дотор баривчлагдсан сэжигтэн шүүхэд ахиад гомдол гаргах ийм 3 үндэслэлээр энэ заалтыг нэлээн хумьж, эрсдэлийг нь бага хасгасан гэж ингэж ажлын хэсэг үзсэн учраас энэ заалтыг бол энэ чигээр нь оруулаад, одоогийн практикийг ингээд үргэлжлүүлээд явъя гэсэн ийм байдалтай байгаа. Өмнө нь үйлчилж байсан 31.5 дээр яг энэ зүйл ангиар энэ хэсгээр нийт баривчлах ажиллагааны 13 орчим хувь нь явагддаг байсан нь комиссын судалгаан дээр гарсан. Гэхдээ энэ дээр бол шүүхийн практикт бас хэрэглэхэд төвөгтэй асуудлууд гардаг байсныг саяын 3 зохицуулалтаар хаасан гэж ингэж үзэж байгаа учраас харьцангуй дэвшилттэй заалт болсон гэж ингэж үзэж байгаа.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон.

Л.Данзанноров: Сандаг-Очир гишүүн гишүүний асуултад хариулъя. Тэгээд энд ажлын хэсгийн гишүүд тодорхой асуудлуудаар бас янз бүрийн саналтай л байдаг. Энэ дээр баривчлах, тэр тусмаа хойшлуулиггүйгээр баривчлах асуудал дээр энэ босго нэлээн өндөртэй байя. Харьцангуй энэ субъектив шалгууруудыг байхгүй болгоё гэсэн энэ чиглэлээр нэлээд их нарийн хэдэн талаас нь бас ярилцсан. Хэргийн газарт болон бие, тээврийн хэрэгслээс нь ул мөр илэрнэ гэдэг бол нэлээд бас эрсдэлтэй

зохицуулалт. Янз янзын байдлаар эндээс чинь юу хэргийн шинж тэмдэг илэрлээ, гар хөлийн хурууны хээ илэрлээ гэх шинжээр бас баривчилдаг асуудлууд байгаа. Тэгээд 13 хувь гэдэг бол тийм ч бас бага тоо биш байгаа юм. Тийм учраас энэ дээр нэлээд олон талаас нь ярилцаад ганц юунд нь найдаж гэдэг юм уу, нэлээд ярилцсаны эцэст эргээд 24 цагтаа шүүхийн хяналтад орох юм. Энэ нотолж байгаа зүйлүүд үндэслэл баримтуудаа шүүх дээр 2 талын оролцоо, өмгөөлөгч, прокурорын оролцоотойгоор хэлэлцүүлэг явуулна. Энийг нь үнэхээр баривчлахад, хориход хангалттай юу, үгүй юу гэдэг энэ хэлэлцүүлгээр дамжиж оролцох асуудал байна гэж үзсэн.

2-т, үүний дараа нь бол бас хэрвээ хойшлуулиггүйгээр баривчилсан энэ асуудлууд нь үндэслэлгүй байвал, хүний эрхийн зөрчилтэй байвал эргээд энэнд нь гомдол гаргаж хариуцлага тооцуулах механизмыг нь дахиж энэ нэмэлт, өөрчлөлтийн төсөлдөө оруулж өгсөн. Энэ нь бол 14 хоногийн хугацаанд гомдол гаргаж шийдвэрлүүлнэ гэсэн ийм асуудлууд байгаа. Дээр нь нэмж хэлэхэд саяхан бас хэлэлцэгдээд өнгөрлөө. Аль болох хүнийг хорьж мөрдөх асуудал бол нийтлэг журмаар хэрэглэгдэх ёсгүй гэж олон улсын баримт бичгүүдэд байдаг. Энийг аль болох багасгах үүднээс түрүүнд Энх-Амгалан гишүүний хөндсөн тэр мэдээлэл гэдэг асуудал ч гэсэн нэлээд анхаарал татаж байгаа юм. Энэ бол яг баримтаар давхар нотлогдсон байх энэ агуулга давхар байгаа шүү гэдгийг зайлиггүй хийж өгөх, энийг цаашид энэ хууль хэрэгжүүлэх арга хэмжээний энэ тогтоолдоо их тодорхой тусгах, эсвэл сургалт судалгааны асуудлаар энэ шүүгч нарт прокуроруудад бас нэлээд ойлголт өгөх зайлиггүй шаардлага байгаа гэдгийг бас хэлэх нь зүйтэй гэж бодож байгаа. Энэ бол зөвхөн мэдээлэл гэдэг бол харьцангуй хийсвэр шинжтэй босго багатай байна гэдэг дээр Өмгөөлөгчдийн холбооны байр суурь, өмгөөлөгчдийн байр суурь ийм байсан. Тэгэхдээ ажлын хэсэг

дээр бол нэлээд ярилцаж байгаад энэ нь хуучнаараа үлдчихээд байгаа юм гэдгийг нэмж хэлье ээ.

Д.Цогтбаатар: Ойлголоо. Өөр асуух асуулттай гишүүд байна уу. Байхгүй бол дэмжье гэсэн томъёоллоороо санал хураалтаа явуулъя. 91%-аар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 3 саналтай байгаа.

12.Төслийн 4 дүгээр зүйлийн “15.8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “тухайн шатын шүүхийн Ерөнхий шүүгч, түүний эзгүйд томилсон шүүгч” гэснийг “давж заалдах шатны шүүх” гэж” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Энэ томъёоллоор дэмжье гэж санал хураалт явуулъя. 83%-ийн саналаар санал дэмжигдлээ.

13.Төслийн 4 дүгээр зүйлийн “31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэснийг хасаж, 31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 3 дугаар зүйлд 6 дахь заалт болгон нэмэх:

“6/31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Мөрдөгч сэжигтнийг баривчлах үед түүнийг ямар хэрэгт холбогдуулан баривчилж байгаа талаар мэдэгдэж, энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан эрхийг сануулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэж санал хураалт явуулъя. Саяын энэ санал хураалгасан юун дээр би нэг зүйлийг зүгээр буруу уншаад явчхаж. Мөрдөгч сэжигтнийг баривчлах үед түүнийг ямар хэрэгт холбогдуулан баривчилж байгаа талаар мэдэгдэж, энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан эрхийг сануулна.”” гэсэн

томъёололтой юм байна шүү. Тийм үгийг нь би засаад уншихлаа.

14.Төслийн 4 дүгээр зүйлийн “31.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн” гэснийг хасаж, 31.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 3 дугаар зүйлд 7 дахь заалт болгон нэмэх:

“7/31.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Сэжигтэнд баривчлах тухай шүүхийн шийдвэрийг танилцуулсан, эсхүл хойшлуулиггүйгээр баривчилсан тохиолдолд энэ хуулийн 31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг танилцуулсан үеэс баривчилсан хугацааг тоолох бөгөөд сэжигтнийг мөрдөн шалгах байгууллагад хүргэх, зайлиггүй эмнэлгийн туслалцаа үзүүлэх, эрүүлжүүлэх, өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзахад зарцуулсан хугацааг энэ хуулийн 31.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан хугацаанд оруулан тооцохгүй. Өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах хугацаа 1 цагаас илүүгүй байна.”” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэж санал хураалт явуулъя. 83,3%-аар санал дэмжигдлээ.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал байхгүй байгаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн найруулгын 1 саналтай байна.

15.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр, томъёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 83,3%-аар санал дэмжигдлээ.

Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Байнгын хорооны гишүүддээ баярлалаа. Ажлын хэсгийн саналыг дэмжиж өгсөнд. Хуулийн хэрэгжих хугацаа дээр түрүүн Энхбаяр сайд чухал санал гаргалаа. Манай ажлын дэд хэсгийнхэн ч гэсэн дэмжээд байгаа юм. Тэгээд энэ дээр нөгөө дэгээрээ өргөн барихдаа тусгай зүйл оруулаагүй учраас дэгийн хуулиараа нэмэлт зүйл оруулж санал хураалгаж болохгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр ийм хувилбар байна. Байнгын хорооны гишүүд дэмжвэл энийг зарчмын хувьд дэмжээд санал хураалгачхаж болж байна. Хуулийн төслөө хэлэлцээд дууссаны дараа хуулийг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх журмын тухай хууль батлаад, Журмын тухай хуульдаа энэ, энэ заалтууд нь тэдэн сарын тэднээс, энэ, энэ заалтууд нь тэдэн сарын тэднээс, энэ энэ нь ердийн журмаар гэдгийг нь заагаад өгчихвөл шууд хэрэгжих бололцоотой ердийн журмаар хэрэгжээд явж байг. Яг цаг хугацаа шаардсан асуудлуудаа хугацаа тавиад өгчихье. Тэгэх юм бол хэдүүлээ процессын дэгийн хуулийнхаа шаардлагыг нэг талаас биелүүлчихнэ, нөгөө талаас хууль хэрэгжүүлэхэд нөгөө бэлтгэл хангах бололцоо гаргаад өгчхөж байгаа юм. Энийг зарчмын санал хураалгаад өгчихвөл бид нар, ажлын хэсэг бэлдчихье.

Д.Цогтбаатар: Тэгвэл дагаж мөрдөх журмын тухай хуулиар энэ юмаа эцэслэн одоо шийдвэрлэхээр болж байна. Энэ саналыг Мөнх-Оргил гишүүн дэвшүүлж байна. Тэгэхээр энэ саналыг дэмжье гэсэн томъёоллоор... тэгэхээр нээрээ тийм байна. Мөнх-Оргил гишүүн ээ, тэгэхээр хууль санаачлагчийнхаа бүрэн эрхийн хүрээнд та энэ хуулийг санаачилж оруулж ирэх нь байна шүү дээ. Тэгвэл үүгээр дэмжье гээд санал хураалт явуулах уу. 66.7%-аар санал дэмжигдлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Байнгын

хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил танилцуулна.

15.49 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.
Дараагийн 7 хоногтоо л явчих байх.

Засгийн газар 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийе ээ.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил танилцуулна. Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын Улсын Их хуралд өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар, Улсын Их Хурал 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн. Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажил х хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргилоор ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг,

Мөнхцэцэг, Пүрэвдорж, Раднаасэд нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бөгөөд ажлын дэд хэсэг 4, ажлын хэсэг 1 удаа тус тус хуралдлаа.

Ажлын хэсгийн хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг Засгийн газрын өргөн мэдүүлсэн төслөөс ажлын хэсэг дээр хэлэлцэж байгаа төслийн гол ялгаа энэ хууль батлагдаад ямар үр дүн гарах, шүүхийн шийдвэр гардуулах ажиллагааг хэрхэн түргэн шуурхай зохион байгуулах, барьцааны зүйлийн талаар асуулт асууж, хариулт авсан.

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгийн саналаар дараах зарчмын асуудлуудыг өөрчлөн тусгалаа.

Нэхэмжлэлийн шаардлагын төрлийг нэмэгдүүллээ. Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд тусгайлсан журмаар шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах нэхэмжлэлийн төрлийг тодорхойлсон. Ингэхдээ гэрээний үүргийг үндэслэн мөнгөн хөрөнгө гаргуулах шаардлагаас үүдэлтэй маргааныг хянан шийдвэрлэхээр заасан. Харин ажлын хэсгээс дараах шаардлагаас үүссэн маргааныг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж, нэмж оруулахаар санал оруулж байна.

Үүнд: Хүний эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулахтай холбоотой мөнгөн хөрөнгө гаргуулах, төсөлд заасан мөнгө, хөрөнгийн үнийн дүнгийн доод хэмжээнээс үл хамаарах дараах шаардлагыг нэмж тусгалаа. Хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх зорилгоор эд хөрөнгө, эрхийг битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдаа явуулах

ажиллагаатай холбоотой гомдол, ажилд эгүүлэн тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх олговор гаргуулах нэхэмжлэл, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлж буй өнөөгийн практикт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа буюу хөрөнгө битүүмжилсэн, хураах, хөрөнгийн үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдааг явуулах ажиллагаа тус бүрийг шүүхээр хянуулах нь түгээмэл байна. Энэ төрлийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцаас хамаарч шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дунджаар 1-4 жилийн хугацаанд түдгэлзэж, энэ хугацаанд төлбөрт хураагдсан хөрөнгийн зах зээлийн үнэлгээнд өөрчлөлт орох, чанар байдал дордох, төгрөгийн хани сулрах зэргээр төлбөр авагч төлбөр төлөгчийн хэн хэн нь нэмж хохирох сөрөг үр дагавар бий болж байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой гомдол, нэхэмжлэл нь мөнгөн хөрөнгө гаргуулах тухай маргаан биш бөгөөд маргааны зүйл нь шийдвэр гүйцэтгэгчийн явуулсан тухайн төрлийн ажиллагаа хуульд нийцсэн эсэх тухай асуудал байдаг. Иймд энэ төрлийн нэхэмжлэлд үнийн дүн тодорхойлох боломжгүй юм. Үндсэн нэхэмжлэл буюу гэрээний үүрэг, гэм хор зэргээс шалтгаалсан хохирол, төлбөр гаргуулах гомдол, нэхэмжлэлийг шүүх өмнө нь ердийн журмаар хянан хэлэлцэж зохигчид 3 шатны шүүхэд хандан уг асуудал эцэслэн шийдвэрлэгдсэн байдаг. Иймд дээрх шаардлагын хүрээнд тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх маргааны төрөлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор эд хөрөнгө, эрхийг битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдаа явуулах ажиллагаатай холбоотой гомдлыг ажлын хэсгээс нэмж тусгасан болно.

Ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх олговор гаргуулах нэхэмжлэлийн шаардлага нь нэхэмжлэгчийг урьд ажилд эгүүлэн

тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэртэй боловч уг шийдвэрийг биелүүлээгүйн улмаас ажилтан ажилдаа орж хөдөлмөр эрхлэх, цалин хөлс олж авах эрх нь зөрчигдсөнтэй холбоотой үүсдэг маргаан байна. Энэ төрлийн маргаан практикт ихэнхдээ шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа боловч ажилтныг тодорхой бус зарим шалтгаанаар ажилд нь эгүүлэн авахаас ажил олгож цааргалсан, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашируулдагтай холбоотой байдаг. Ажилтныг ажилд эгүүлэн тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэртэй ажилд эгүүлэн томилох үр дагавар нэгэнт бий болсон маргаан байх тул энэ төрлийн маргааныг тусгайлсан журмаар шийдвэрлэхэд төдийлөн хүндрэлтэй бус гэж үзэж байгаа юм.

Барьцааны зүйлээс үүргийн гүйцэтгэлийг хангуулах шаардлагыг Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсөлд тусгасан. Гэвч барьцааны шаардлага бүхий нэхэмжлэлийг үнийн дүнгээс үл хамаарах шаардлага гэх агуулгаар өөр хэсэгт оруулах, томьёолох саналыг ажлын хэсгээс оруулсан. Шүүхэд гарч буй нэхэмжлэлийг өргөн хүрээнд мөнгөн хөрөнгө гаргуулах болон хөрөнгийн шаардлага гэж 2 ангилна. Барьцааны зүйлээс үүргийн гүйцэтгэлээ хангуулах шаардлага нь хөрөнгийн шаардлагад хамаарах бөгөөд анхдагч үүрэг буй зээлийн маргаан гэх мэт мөнгөн хөрөнгө гаргуулах өөр шаардлагыг хангасны үндсэн дээр шийдвэрлэгддэг маргаан байдаг. Барьцааны шаардлагыг хангана гэдэг нь тодорхой хөрөнгийг худалдан борлуулж үнийн дүнгээс зээлийн болон анхдагч бусад шаардлагыг биелүүлэх, үлдсэн мөнгөн дүнг өмчлөгчид буцаан өгөх үр дагавартай. Энэ агуулгаар барьцааны шаардлагыг мөнгөн хөрөнгө гаргуулах шаардлага гэж үздэггүй тул үнийн дүнгээс үл хамаарах шаардлагад оруулан томьёолсон болно.

Төсөлд бага үнийн дүн бүхий гэрээний үүргийг хангасан барьцааны

шаардлагыг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэхээр заасан бөгөөд энэ нь үндсэн үүрэг буюу анхдагч шаардлага нь үргэлж бага үнийн дүнтэй байхыг шаардах юм.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд гэр бүлийн харилцаанаас үүсэх хэрэг маргааныг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэхгүй байхаар тусгасан бөгөөд ажлын хэсгээс өв залгамжлалтай холбогдолтой маргааныг энэ төрөлд нэмж тусгасан. Өөрөөр хэлбэл гэр бүл, өв залгамжлалтай холбоотой бүх төрлийн маргааныг үнийн дүнгээс үл хамааран ердийн журмаар хянан шийдвэрлэхээр санал болгож байгаа юм.

Хугацааг тодорхой тусгалаа. Ердийн журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай харьцуулахад тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хугацааны хувьд тодорхой, хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд шүүх хуралдааныг аль болох хойшлуулишгүйгээр I удаагийн шүүх хуралдаанаар шийдвэрлэх шаардлагатай юм. Иймд дээрх шаардлагыг хангах зорилгоор хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 45 хоног, давж заалдах шатын шүүхээс хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан бол шүүгч хэргийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэгдэхээр хугацааг тодорхой зааж өглөө.

Түүнчлэн талуудын эрх, хууль, ёсны, ашиг сонирхлыг тэнцвэртэй хангах зорилгоор дээрх хугацааг шүүгчдийн зөвлөгөөнөөр I удаа 14 хоногоор сунгах зохицуулалтыг нэмж, тусгалаа.

Хэрэг үүсгэх, нэхэмжлэл гардуулах журмыг нарийвчлан тодруулж өглөө. Тухайлбал шүүгч энэ хуулийн тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэгдэх хэргийн хуульд заасан шаардлага нь хангагдсан бөгөөд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлгүй байвал, үндэслэл байхгүй гэж үзвэл

нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 5 хоногийн дотор иргэний хэрэг үүсгэх тухай захирамж гаргана. Мөн хариуцагчид мэдэгдэх хуудсыг хүргүүлэхдээ нэхэмжлэлийн хувийг хэргийн оролцогчийн эрх, үүргийн талаарх дэлгэрэнгүй тайлбарын хамт илгээнэ. Хэрэв мэдэгдэх хуудас нэхэмжлэлийн хувь тайлбарыг баталгаат шуудангаар илгээсэн, эсвэл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлснийг энэ хуулийн 77 дугаар зүйлд заасны дагуу хариуцагч хүлээн авсан бол ийнхүү хүлээн авсан өдрөөр, энэ хуулийн 75¹.4.4-д заасны дагуу хүргүүлсэн бол мөн зүйлд заасан мэдэгдэх хуудас хүлээн авсан тооцох өдрийг нэхэмжлэлийн хувийг гардаж авсан өдөр гэж үзнэ.

Түүнчлэн ажлын хэсгээс тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх нэхэмжлэл, хариу тайлбар, хэргийн оролцогчийн эрх, үүргийн талаарх тайлбарын загварыг Улсын дээд шүүхээс батлах зохицуулалтыг нэмж тусгасан. Ингэснээр бага үнийн дүнтэй тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх, хэргийн нэхэмжлэлийг гаргах, хариу тайлбарыг хялбар байдлаар гаргах боломжтой болох юм. Сөрөг нэхэмжлэл нэхэмжлэл гаргах нөхцөлийг бүрдүүлээ. Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тэгш зарчмыг баримтлах зорилгоор хариуцагч сөрөг нэхэмжлэл гаргах зохицуулалтыг нэмж тусгалаа. Ингэхдээ тодорхой шалгуур хугацааг тогтоолоо. Тухайлбал зохигчоос гаргаж байгаа сөрөг нэхэмжлэлийн шаардлагын мөнгөн дүнгийн хэмжээ нь бага үнийн дүнгийн хязгаарт багтсан байх, хариуцагч нэхэмжлэлийг гардаж авснаас хойш 7 хоногийн дотор сөрөг нэхэмжлэл гаргах, зохигч үндсэн ба сөрөг нэхэмжлэлийг гардан авснаас хойш 5 хүртэл хоногийн дотор нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн эсвэл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлэх зэрэг процесс ажиллагааг хугацаатайгаар оруулж өгсөн.

Түүнчлэн тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусдын эрх хөндөгдсөн тохиолдолд бие даасан шаардлага хангаагүй гуравдагч этгээдийг оролцуулахаар зохицууллаа.

Гэрчийн мэдүүлэг. Гэрч мэдүүлгээ үнэн зөв мэдүүлэхээ илэрхийлж, мэдүүлгээ нотариатаар баталгаажуулан мэдүүлсэн. Мөн дууны, дүрсний, дуу дүрсний бичлэгийн тусламжтай мэдүүлгээ гаргасныг шүүх хангалттай гэж үзвэл нотлох баримтаар үнэлж болох зохицуулалтыг нэмж тусгалаа.

Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжих нөхцөлийг чангатгалаа. Хуулийн төсөлд тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талууд хүсэлт гаргасан тохиолдолд ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжүүлэхээр тусгасан байсныг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах хийдэл үүсэх магадлалтай гэж үзлээ.

Иймд дараах 2 нөхцөлд шүүгч ердийн журмаар шийдвэрлүүлэхээр шилжүүлэх захирамж гаргахаар тусгасан. Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрөлд хамаараагүй, эсхүл тухайн хэрэг нь эрх зүйн шинэ ойлголт хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой байж магадгүй гэж шүүгч үзсэн тохиолдолд. Харин талуудын хүсэлтээр ердийн журамд хэзээ ч шилжиж болохоор хуулийн төсөлд тусгасан байсан зохицуулалтыг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэгдэх ач холбогдлыг бууруулах, хэргийг хурдан шуурхай, хялбар шийдвэрлэх, үндсэн зорилгод нийцэхгүй байна гэж үзсэн тул хассан болно.

Давж заалдах гомдол гаргах. Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг зохигчид эс

зөвшөөрвөл шийдвэрийг гардуулснаас хойш 7 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болох бөгөөд давж заалдах шатны шүүх хэргийг эцэслэн шийдвэрлэнэ. Харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөн бол Давж заалдах шатны шүүхээс хэргийг анхан шатны шүүхэд дахин хянан шийдвэрлэхээр буцаахаар тусгалаа.

Мөнгөн торгууль оногдуулах. Материаллаг хуулиар оногдуулах хариуцлагын арга хэмжээг процессын хуульд тусгасан байсныг хассан болно. Өөрөөр хэлбэл хуулийн төслийн 1 дүгээр зүйлд 75¹.10.1-д энэ хуулийн 75¹.2-т заасныг зөрчсөн бол шүүгч шийтгэвэр гарган уг этгээдийг 100 мянга хүртэл төгрөгөөр торгоно гэж хариуцлагын санцыг оруулсан байсныг хассан.

Хуулийг дагаж мөрдөх хугацааг тогтоолоо. Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах шүүхийн хүний нөөц, чадавхыг нэмэгдүүлэх, иргэн, хуулийн этгээдэд хуулийг сурталчлах, цахим хэлбэрээр шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргүүлэх техникийн боломжийг бий болгох зэрэг бэлтгэл ажлыг хангах зорилгоор хуулийг 2024 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Мөнх-Оргил гишүүдийн микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Уучлаарай тасалдчихлаа. ... зорилгоор хуулийг 2024 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөх хугацааг тогтоолоо. Тухайлбал Цахим хөгжлийн яамны мэдээллээр и-монголиа буюу иргэн, хуулийн этгээдтэй харилцах, төрийн байгууллагаас харилцах төрийн мэдээллийн нэгдсэн системийг 450, 500 мянган хүн идэвхтэй ашигладаг, 1,7 сая хүн бүртгэлтэй, үүнээс 87% нь гар утаснаас, 12% нь компьютероос, 1,2% нь Түц машинаас ашигладаг байна. Мөн 1 жилийн дотор компани и-бизнес профайлтай болохоор төлөв ажиллаж байна. Иймд цахимаар мэдэгдэх хуудсыг

хүргүүлэх нь хугацаа хэмнэх боломжтой гэж үзэн, мэдэгдэх хуудсыг цахимаар илгээснээс хойш 14 хоног өнгөрсөн бол хүлээн авснаар тооцохоор тусгасныг өөрчлөн 7 хоног болгон өөрчиллөө.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй 1 саналын томъёолол бэлтгэлээ.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Улсын дээд шүүхийн Иргэний хэрэг хэргийн танхимын шүүгч Н.Баярмаа, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Б.Ундрах, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Баасанжав, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Жамъянхүү, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн шинжээч М.Цолмон, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дэд дарга Оюунцэцэг.

Хуулийн төслийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү. Алга байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. 1 саналтай байгаа.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 1, 2 дугаар зүйл болгох:

“1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай Долдугаар¹ бүлэг нэмсүгэй:

**“ДОЛДУГААР¹ БҮЛЭГ
Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа**

75¹ дүгээр зүйл.Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх хэрэг

75¹.1.Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй мөнгөн хөрөнгө гаргуулах дараах нэхэмжлэлийг шүүгч дангаар тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ:

75¹.1.1.бүх төрлийн гэрээний дагуу мөнгөн хөрөнгө гаргуулах;

75¹.1.2.дундын өмчийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардал гаргуулах;

75¹.1.3.хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс гаргуулах;

75¹.1.4.бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд гэм хор учруулсны улмаас мөнгөн хөрөнгө гаргуулах.

75¹.2.Дараах нэхэмжлэлийг үнийн дүнгээс үл хамааран шүүх тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ:

75¹.2.1.шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор эд хөрөнгө, эрхийг битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдаа явуулах ажиллагаатай холбоотой гомдол;

75¹.2.2.энэ хуулийн 75¹.1.1-д заасан гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах нэхэмжлэл;

75¹.2.3.ажилд эгүүлэн тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх олговор гаргуулах нэхэмжлэл.

75¹.3.Эрх зүйн нэг маргаанаас үүдэлтэй шаардлагыг хэд хэдэн нэхэмжлэлээр хэсэгчлэн гаргахыг хориглоно.

75¹.4.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуулиар тогтоосон журмын дагуу шийдвэрлэнэ.

75¹.5.Гэр бүл, өв залгамжлалын холбогдолтой бүх төрлийн хэрэгт тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх журам үйлчлэхгүй.

75² дугаар зүйл.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх зарчим, хугацаа

75².1.Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэг шүүх хуралдаанаар, бичмэл болон цахим нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэнэ.

75².2.Зохигч шүүх хуралдаанаас өмнө, энэ бүлэгт заасан хугацааны дотор өөрийн шаардлага, татгалзлын үндэслэл болж байгаа байдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй.

75².3.Иргэний хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 45 хоног, давж заалдах шатны шүүхээс хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ.

75².4.Энэ хуулийн 75².3-т заасан хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 14 хүртэл хоногоор сунгаж болно.

75³ дугаар зүйл.Хэрэг үүсгэх, нэхэмжлэл гардуулах

75³.1.Шүүгч энэ хуулийн 75¹ дүгээр зүйлд заасан шаардлага хангагдсан бөгөөд энэ хуулийн 65.1-д заасан үндэслэл байхгүй гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 5 хоногийн дотор иргэний хэрэг үүсгэх тухай захирамж гаргана.

75³.2.Энэ хуулийн 75⁴ дүгээр зүйлд заасны дагуу хариуцагчид мэдэгдэх хуудсыг хүргүүлэхдээ нэхэмжлэлийн хувийг хэргийн оролцогчийн эрх, үүргийн тайлбарын хамт илгээнэ. Хэрэв мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийн хувь, эрх, үүргийн тайлбарыг баталгаат шуудангаар илгээсэн, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлснийг энэ хуулийн 77 дугаар зүйлд заасны дагуу хариуцагч хүлээн авсан бол ийнхүү хүлээн авсан өдрөөр, энэ хуулийн 75⁴.4-т заасны дагуу хүргүүлсэн бол мөн зүйлд заасан мэдэгдэх хуудас хүлээн авсанд тооцох өдрийг нэхэмжлэлийн хувийг гардаж авсан өдөр гэж үзнэ.

75³.3.Нэхэмжлэл, хариу тайлбар, хэргийн оролцогчийн эрх, үүргийн тайлбарын загварыг Улсын дээд шүүх батална.

75⁴ дүгээр зүйл. Мэдэгдэх хуудсыг хүргүүлэх

75⁴.1. Шүүх энэ хуулийн 77.2-т заасны дагуу мэдэгдэх хуудсыг баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлсэн боловч хариуцагч тухайн хаягт оршин суудаггүй, үйл ажиллагаа явуулдаггүй бол хариуцагч иргэний болон хуулийн этгээдийн бүртгэлийн дугаар, эсхүл регистрийн дугаарыг мэдээлсэн нэхэмжлэлийн тухайд албан ёсны хаягийг улсын бүртгэлийн байгууллагаас тодруулах ажиллагааг шүүх санаачилгаараа хийнэ.

75⁴.2. Энэ хуулийн 75⁴.1-д заасны дагуу улсын бүртгэлийн байгууллагаас тодруулж ирүүлсэн хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн боловч хариуцагч тухайн хаягт оршин суудаггүй, үйл ажиллагаа явуулдаггүй бол иргэн, хуулийн этгээдтэй төрийн байгууллагаас харилцах төрийн мэдээллийн нэгдсэн системийн иргэний болон хуулийн этгээдийг итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээдийн бүртгэлийн дугаар бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээнэ.

75⁴.3. Энэ хуулийн 75⁴.2-т заасан цахим шуудангийн хаягаас гадна хариуцагчийн албаны болон хувийн цахим шуудангийн хаягийн мэдээллийг нэхэмжлэлд тусгасан бол эдгээр хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг давхар илгээнэ.

75⁴.4. Энэ хуулийн 75⁴.2, 75⁴.3-т заасны дагуу цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээснээс хойш 7 хоног өнгөрсөн бол мэдэгдэх хуудсыг хүлээн авсанд тооцно.

75⁵ дугаар зүйл. Хариу тайлбар, сөрөг нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлэх, гуравдагч этгээд оролцох

75⁵.1. Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэгтгэх, тусгаарлах, бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд, хамтран нэхэмжлэгч, хамтран хариуцагч татан оролцуулах ажиллагаа хийгдэхгүй.

75⁵.2. Хариуцагч нэхэмжлэлийг гардаж авснаас хойш 7 хоногийн дотор сөрөг нэхэмжлэл гаргаж болно.

75⁵.3. Сөрөг нэхэмжлэл энэ хуулийн 73, 75¹ дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

75⁵.4. Зохигч үндсэн ба сөрөг нэхэмжлэлийг гардан авснаас хойш 5 хүртэл хоногийн дотор нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлэх үүрэгтэй.

75⁵.5. Нэхэмжлэгч иргэний хэрэг үүсгэснээс хойш 5 хоногийн дотор энэ хуулийн 75¹ дүгээр зүйлд заасан шаардлага, үндсэн нэхэмжлэлд заасан үндэслэлийн хүрээнд нэхэмжлэлийн шаардлагаа нэг удаа нэмэгдүүлж болно. Нэхэмжлэлийн шаардлагыг нэмэгдүүлснийг хэргийн оролцогчид мэдэгдэнэ.

75⁵.6. Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусдын эрх хөндөгдсөн тохиолдолд тэдгээр нь бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдээр оролцож болно.

75⁶ дугаар зүйл. Гэрчийн мэдүүлэг

75⁶.1. Гэрч энэ хуулийн 43.3-т заасан эрх, үүргийг ойлгосны үндсэн дээр үнэн зөв мэдүүлснээ илэрхийлэн, нотариатаар гэрчлүүлсэн мэдүүлгийг шүүхэд ирүүлсэн нь хангалттай гэж шүүх үзвэл нотлох баримтаар үнэлж болно.

75⁶.2. Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн тусламжтай гэрч, шүүгч, зохигч нэгэн зэрэг холбогдон авсан гэрчийн мэдүүлгийг хангалттай гэж шүүх үзвэл нотлох баримтаар үнэлж болно.

75⁶.3. Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжүүлсэн нь гэрчийн мэдүүлгийг энэ хуулийн 75⁶.2-т заасны дагуу үнэлэхэд саад болохгүй.

75⁷ дугаар зүйл. Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагаа үргэлжлэх

75⁷.1. Шүүгч иргэний хэрэг үүсгэснээс хойш дараах нөхцөл байдал тогтоогдвол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулах тухай захирамж гаргаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлнэ:

75⁷.1.1. нэхэмжлэл гаргах, эсхүл иргэний хэрэг үүсгэхдээ энэ хуулийн 75¹ дүгээр зүйлд заасныг зөрчсөн;

75⁷.1.2. тухайн хэрэг нь эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой байж болзошгүй гэж үзсэн.

75⁷.2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулах тухай шүүгчийн захирамжид гомдол гаргахгүй.

75⁷.3. Хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхээс тогтоосон тов ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хүчинтэй хэвээр байна.

75⁷.4. Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхээр үргэлжлүүлсэн нь хэрэг хянан шийдвэрлэх хугацааг шинээр тоолох үндэслэл болохгүй.

75⁸ дугаар зүйл. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх

75⁸.1. Шүүгч иргэний хэрэг үүсгэснээс хойш энэ хуулийн 74.1-д заасан үндэслэл бүрдвэл хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэнэ.

75⁹ дүгээр зүйл. Хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн

шүүхийн шийдвэр

75⁹.1. Энэ хуулийн 75⁷.1-д зааснаас бусад тохиолдолд шүүх энэ хуулийн 75¹.1, 75¹.2-т заасан шүүх хуралдаанаас шийдвэр гаргана.

75⁹.2. Энэ хуулийн 75⁹.1-д заасан шийдвэр нь удиртгал, үндэслэх, тогтоох хэсэгтэй байх бөгөөд үндэслэх хэсэгт нэхэмжлэлийн шаардлага, татгалзал, шийдвэрийн үндэслэлийн товч агуулгыг дурдана.

75⁹.3. Шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор энэ хуулийн 75³.2-т заасны дагуу зохигч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид гардуулна.

75⁹.4. Энэ хуулийн 75⁹.2 дахь хэсэг давж заалдах шатны шүүхийн магадлалд нэгэн адил үйлчилнэ. Шийдвэр, магадлалын бүтэц, боловсруулах аргачлалыг Улсын дээд шүүх батална.

75¹⁰ дугаар зүйл. Шүүхийн шийдвэрээр нэмэлт хугацаа тогтоох, хуваарь гарган хэсэгчлэн төлөх

75¹⁰.1. Нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн, эсхүл хэсэгчлэн хангасан бол хариуцагчийн санхүүгийн байдал, харгалзвал зохих бусад зайлиггүй шалтгаанаар, хариуцагчийн хүсэлтэд үндэслэн шийдвэрийг биелүүлэх нэмэлт хугацаа тогтоох, эсхүл хуваарийн дагуу хэсэгчлэн төлөхөөр шүүхийн шийдвэрт

зааж болно. Нэмэлт хугацаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш зургаан сараас илүүгүй байна.

75¹¹ дүгээр зүйл. Давж заалдах гомдол гаргах

75¹¹.1. Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ хуулийн 75⁹.3-т заасны дагуу гардуулснаас хойш 7 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болно.

75¹¹.2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд давж заалдах шатны шүүх хэргийг эцэслэн шийдвэрлэнэ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Н.Алтанхуяг, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд цаашид “ажлын хэсэг” гэх. Энэ томъёоллоор дэмжье гэж санал хураалт явуулъя. Пүрэвдорж гишүүн дэмжсэн байна. Санал энд татгалзсанаар гарчихлаа. Тэгэхлээр Пүрэвдорж гишүүнийг дэмжсэнээр тооцъё гэж би протоколд бүртгүүлмээр байна. Тэгэхээр энэ хувь чинь хэд болох вэ. Одоо бол 58%-аар дэмжигдлээ. 63,2%-аар дэмжигдлээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил танилцуулна.

16.19 цаг.

Дараагийн асуудалд орохын өмнө Мөнх-Оргил сайд аа, нэг юу би түрүүн орхиод явчхаж энийг танилцуулаад явчихъя. Энэ нөгөө Эрүүгийн хэрэг хянан

шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэх асуудал байгаа.

Энийг ингээд зүйл бүрээр нь хэлэлцье.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй саналгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналгүй.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналгүй.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна. Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналгүй.

Ингээд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Мөнх-Оргил гишүүн уншина гээд түрүүн танилцуулсан.

Дараагийн асуудалдаа орё. 3 дугаар асуудал асуудал. Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа нарын 19 гишүүн 2023 оны 12 дугаар сарын 8-ны өдөр өргөн мэдүүлсэн Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай

хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийх асуудал байгаа.

Төсөл санаачлагч ирээгүй байгаа тул төсөл санаачлагчийг иртэл энэ асуудлыг хойшлуулъя.

16.21 цаг.

“Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулах байсныг ажлын хэсгийн ахлагч Мөнхбаатар хойшлуулах санал гаргасан тул өнөөдрийн хуралдааны хэлэлцэх асуудлаас хойшлууллаа. Хасаж хойшлууллаа.

Ингээд дараагийн асуудалдаа орёё. Шүүх байгуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна. Дарга нь Раднаасэд гишүүн. Тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлж дууслаа.

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Ингэе түр хүлээж байгаарай, санал хураалтыг түр хойшлуулъя. Ажлын хэсгийн тогтоолын төслөө тараачихсан байгаа. Гэхдээ би уншаад танилцуулчихъя. Нөгөө төслийг танилцуулчихсан байгаа юм чинь. Би ажлын хэсгээ л танилцуулчихъя. Ажлын хэсгийн ахлагч нь Ш.Раднаасэд Улсын Их

Хурлын гишүүн, гишүүд Г.Амартүвшин Улсын Их Хурлын гишүүн, Д.Ганбат Улсын Их Хурлын гишүүн, Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын гишүүн, Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын гишүүн, Ц.Мөнх-Оргил Улсын Их Хурлын гишүүн, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Г.Золжаргал Хууль эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх.

Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж байгаа. Энд Ч.Хосбаяр Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн, Г.Алтанчимэг Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн, Д.Мөнхтуяа Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн, Б.Батцэрэн Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч, Ц.Цогт Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүгч, Н.Баярмаа Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын шүүгч, Л.Энхбилиг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, А.Насандэлгэр Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Н.Отгончимэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, С.Энхтөр Шүүхийн сахилгын хорооны гишүүн, Г.Эрдэнэбулган Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, О.Мөнхбаатар Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга, Ш.Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах шинжээч, Д.Сүхбаатар Монголын Өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, Б.Болд Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч, Бадамрагчаа Нээлттэй нийгэм формын менежер, Б.Галсанбат Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт. Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудаас мэргэжлийн хүмүүсийг

оролцуулж ажиллуулахыг ажлын хэсгийн ахлагч Раднаасэдэд зөвшөөрсүгэй. Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар гэсэн байна. Энийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүдээ саналаа өгөөрэй. 66,7 хувиар санал дэмжигдлээ.

16.25 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.
Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 1 дүгээр сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл.

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 1 дүгээр сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье ээ.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна.

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 1 дүгээр сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 66,7 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Оролцсон гишүүддээ баярлалаа.

16.27 цаг

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ